




ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь анх 1965 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 126 дугаар тогтоолоор Гадаад мэргэжилтэнд үйлчлэх авто бааз нэртэйгээр үүсгэн байгуулагдсан Монгол улсын нийтийн тээврийн үйлчилгээний анхдагч байгууллагын нэг юм. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр 1991 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны 356 дугаар тогтоолоор

Автобус-3 компани, 2014 онд Нийслэлийн Засаг даргын А/290 дүгээр захирамжаар “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын 3-р бааз, 2018 оны НИТХ-ын тэргүүлэгчдийн А/73 тогтоолоор “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ болж үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Тус байгууллага нь 5 хэлтэс, 493 албан хаагч, инженер техникийн ажилтантайгаар хотын төвийн 6, хот орчмын 6, нийт 12 чиглэлд шугамын 70 гаралтыг 114 хөдлөх бүрэлдэхүүнтэйгээр Нийслэлийн зорчигч тээврийн нийт гаралтын 7,8 хувь, зорчих урсгалын 17 хувийг тээвэрлэж иргэддээ соёлтой боловсон, ая тухтай түргэн шуурхай үйлчлэн ажиллаж байна.



ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

1.1. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ, НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ:

6.3.14. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

1.1.1.(6.3.14.1) Цахилгаан эх үүсвэрээр ажилдаг тээврийн хэрэгслүүдийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж цэгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотгоор байгуулна.

1.1.2. (6.3.14.2.) Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

1.1.3. "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилгын II ээлж барих ажлыг үрэгжлүүлэх

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

2.1. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ

2.1.1. 2022 онд хэрэгжүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан

ГУРАВДУГААР БҮЛЭГ: "БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН" БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:

3.1.1. Нийтийн тээврийн газартай ажил үйлчилгээний гэрээг байгуулан, сар бүр дүгнүүлж, гэрээний үүргийн биелэлтийг тогтмол 95%-иар биелүүлж ажиллах:

3.1.2. Нийтийн тээврийн шугамын үйлчилгээний цаг, рейсийн алдагдалгүй, смартын ТВОХ-ийн зөрчлийг бууруулж ажиллах

3.1.3. Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулж, санал гомдлыг бууруулж ажиллах

3.1.4. Тээврийн хэрэгслийн жолоочоос шалтгаалсан ашиглалтын саатал, зам тээврийн осол зөрчлийг бууруулж ажиллах

3.1.5. Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг техникийн бэлэн байдалд тогтмол үзлэг хийж, илэрсэн эвдрэл гэмтлүүдийг богино хугацаанд чанартай засварлан техникийн бэлэн байдлын коэффициентийг 82.5 %-иас бууруулахгүй ажиллах

3.1.6. Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг хавар, намрын техникийн улсын үзлэг оношилгоонд жилд 2 удаа хуваарийн дагуу хамруулах

3.1.7. Шугамын үйлчилгээний тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, угаалга, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвших.

3.1.8. Батлагдсан цаг графикийн дагуу нийтийн тээврийн шугамын үйлчилгээний өглөөний эх авалт, оройн буултыг бүрэн биелүүлж ажиллах

3.1.9. Тээврийн хэрэгслийг чиглэлийн хаяг, замнал, гаралтын дугаар, рейс цагийн графикаар бүрэн хангаж, шугамын үйлчилгээнд гаргах

3.1.10. Жолооч нарыг стандарт шаардлагын дагуу ажлын хувцсаар хангаж, шугамын үйлчилгээнд тогтмол өмсүүлж хэвшүүлэх

3.1.11.Шалгагч нарыг хуваарийн дагуу шугамын автобусанд зорчигч нарт зөвлөгөө өгөх, хяналт тавьж ажиллуулах.

3.1.12.Тээврийн хэрэгслийн ТҮ I,II-ыг батлагдсан хуваарийн дагуу тогтмол хийж, шаардлагатай үед тодотголыг сар бүрийн 20-ны дотор хийж, батлуулах.

3.1.13.Батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт хөдлөх бүрэлдэхүүний урсгал засварын ажил зохион байгуулах

3.1.14.Автобусны техникийн саатлыг 2021 оноос 50% -иар бууруулах

3.1.15.Нийт хөдлөх бүрэлдэхүүний гадна өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор кузов засварын ажлыг зохион байгуулах.

3.1.16.2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжүүлж ажиллах

3.2.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ)

3.2.1.УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ЗГ-ын тогтоол, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, НЗД-ын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.2.Нийслэлийн засаг даргаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, хэрэгжилтийн мэдээ тайланг хугацаанд нь НЗДТГ-т хүргүүлж ажиллах.

3.2.3.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн захиргааны албан хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг үнэн зөв, хуулийн хугацаанд хүргүүлж ажиллах.

3.2.4.Гамшгийн үед байгууллагад авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах

3.2.5.Байгууллагын "Ажилтнуудын ёс зүйн дүрэм"-ийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3.2.6.Хөдөлмөрийн аюулгүй байдалд тавих үзлэг, шалгалт хийх, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, чанаржуулах ажлыг зохион байгуулах.

3.2.7.Ажилчдыг шаардлагатай нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.

3.2.8.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллах

3.2.9.Ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.10.Байгууллагын 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу ажилчдад зориулсан сургалтыг зохион байгуулах

3.2.11.Орон гэргүй, түрээсийн орон сууцад амьдарч байгаа ажилтнуудын асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах.

3.2.12.Байгууллагын ажилчдын цэцэрлэгийн насны хүүхдүүдийг 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгт хамруулж, урлаг спортын авъяастай хүүхдүүдэд урамшуулал олгох ажлыг зохион байгуулах.

3.2.13.Байгууллагын захиргаа болон ҮЭ-ийн хороо хоорондын "Хамтын гэрээ"-ний дагуу ажилчдын нийгмийн асуудлыг шийдэж ажиллах

3.2.14.Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг стандартын дагуу явуулж, тайлан гаргаж ажиллах.

3.2.15.Байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийг хийж ажиллах.

3.2.16.Хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллаж, тайлан гаргах.

3.2.17.Байгууллагын ажилчид болон гадны байгууллага, иргэдээс өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайлан мэдээг НЗДТГ-т хугацаанд нь хүргүүлж ажиллах

3.2.18. Нийт ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх зорилгоор хөгжөөнт болон спортын тэмцээн, уралдаан, наадам, явган аялал, цасны баяр зохион байгуулах

3.2.19. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn, цахим хуудсыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглах

3.2.20. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг хэрэглэж хэвших

3.2.21. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр шинэчлэх

3.2.22. Байгууллагын хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, аливаа эрсдэлээс сэргийлэх, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, ажилчдад хууль эрх зүйн зөвлөгөө өгөх

3.2.23. Эрхлэх асуудлын хүрээнд үүссэн шүүхийн маргааны шийдвэрлэлт, явц, үр дүнгийн талаар дээд шатны байгууллагад тогтоосон хугацаанд тайлагнаж мэдээлэх

3.2.24. Байгууллагын 2022 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг бодит тоо баримт, мэдээлэлд үндэслэн тооцоолох

3.2.25. Байгууллагын он дамжсан өр авлагыг үе шаттайгаар бууруулж ажиллах.

3.2.26. Тогтоосон хууль тогтоомжийн дагуу байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийж, ашиглалтын хугацаа дууссан, үлдэгдэл өртөггүй, шаардлага хангахгүй болсон тавилга эд хогшлыг актлуулах, саналыг НӨАУГ-т хүргүүлэх.

3.2.27. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу явуулах

3.2.28. Төндөрийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд худалдан авах ажиллагааг 100% цахим хэлбэрээр явуулж, иргэд, олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах

3.2.29. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах

3.2.30. Байгууллагын эхний хагас жилийн тайланд явцын үнэлгээ, жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэх:

3.2.31. Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллах

3.2.32. Тээврийн хэрэгслийн GPS-ийн хяналтын системийг хэрэгжүүлэх, тээврийн хэрэгслийн смартын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.

4.2. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал.

4.3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.

4.4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.

4.5. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал.

ТАВДУГААР БҮЛЭГ:БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Зөвлөмж, хүсэлт, албан даалгавар, албан шаардлагын дагуу ажил зохион байгуулах, хамтарч ажиллах

5.2. Үндсэн чиглэлийн хүрээнд хийсэн ажлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

5.3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ нь 2022 онд Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, нийтийн тээврийн үйлчилгээнд орчин үеийн шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлж, нийслэлийн хөгжил, бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулах, нийтийн тээврээр шуурхай боловсон, ая тухтай үйлчилгээг иргэдэд хүргэх зорилттой ажиллалаа.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ, НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУС БАЙГУУЛЛАГЫН ХАРИУЦАХ 2 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН.

Тусгагдсан зорилт:1.1.1.(6.3.14.1) Цахилгаан эх үүсвэрээр ажилладаг тээврийн хэрэгслүүдийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж, цэгүүдийг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор байгуулах ажлын хүрээнд “Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-д Нийслэлийн агаарын бохирдолыг бууруулах, цахилгаан автобусаар нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлт хийхэд зориулсан орон нутгийн зээллэгийн эргэн төлөлтийг батлагдсан хуваарийн дагуу гүйцэтгэж, тайланг сар, улирал тутамд тайлагнан ажиллана.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:“Нанжин Голден Драгон Бус” ХХК-аас нийлүүлэгдсэн цахилгаан хөдөлгүүртэй их багтаамжийн автобусыг шугам замд цэнэглэх цэнэглэгч төхөөрөмж байрлуулах цэгийг 4:25 чиглэл буюу “Тоосгоны үйлдвэр-3, 4 хороолол”, 4:29 чиглэл буюу “Сэлбэ амралт-Вокзал”, ХО:5 чиглэл буюу “Налайх-Офицеруудын ордон”, байгууллагын хашаан дотор байгуулахаар тодорхойлсон.

Цахилгаан эрчим хүчний мэргэжлийн байгууллага болох “Эрчим хайрхан” ХХК нь автобус паркийн цахилгаан хангамжийн ажил гүйцэтгэх тендерт шалгарч, цахилгаан автобус цэнэглэгч төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэн, тухайн чиглэлүүдэд үйлчилж буй автобуснуудыг бүрэн цэнэглэж, шугамын үйлчилгээг явуулж байна. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн:Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж 17 ширхэгийг суурилуулж ашиглаж, нийтийн тээврийн шугамын үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан.

Зураг 1.4:29 “Сэлбэ амралт



Зураг 2.4:25 “Тоосгоны үйлдвэр



Зураг-3.ХО5:Налайх дүүрэг



Зураг 4. Байгууллагын хашаан доторх цэнэглэх төхөөрөмжүүд



Тусгагдсан зорилт:1.1.2.(6.3.14.2) Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, парк шинэчлэлт хийх ажлын хүрээнд 2022 онд БНХАУ-ын “Нанжин Голден Драгон Бус” компанийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник технологийн, их багтаамжийн цахилгаан эх үүсвэрээр ажилладаг нэг давхар цахилгаан нийтийн тээврийн автобус 1, хоёр давхар цахилгаан нийтийн тээврийн автобус 10 нийт 11 цахилгаан нийтийн тээврийн автобусаар парк шинэчлэлт хийж 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 4:1 буюу “5 шар-Офицеруудын ордон” чиглэлийн үйлчилгээнд нэвтрүүлэн ажилласан.

Парк шинэчлэлтээр шинээр орж ирсэн нэг давхар 36 цахилгаан автобус, хоёр давхар 10 цахилгаан автобус нийт 46 цахилгаан автобусны төлбөрийг хөгжлийн банканд хуваарийн дагуу төлж сар, улирал тутамд тайлагнаж, үндсэн зээл болон хүүгийн төлбөрт 10,935,841.1 (арван тэрбум есөн зуун гучин таван сая найман зуун дөчин нэгэн мянга нэг зуун арван нэгэн төгрөг хорин таван мөнгө) төгрөг төлсөн. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн:

1.Байгаль орчинд ээлтэй 100% цахилгаан автобусаар парк шинэчлэлт хийж 4:1 буюу “5 шар-Офицеруудын ордон” чиглэлд шугамын үйлчилгээнд ажиллуулсан.

2.Үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлсөн.

Тусгагдсан зорилт:1.1.3.“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилгын II ээлж барих ажлыг үрэгжлүүлэх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:“Нийтийн тээврийн автобус парк”-ын барилгын II ээлж барих ажлын хүрээнд тайлант хугацаанд нийт санхүүжилт 21,702,900.0 мян. төгрөгөөс 2022 онд санхүүжих дүн 9,200,000.00 мян.төгрөгийн санхүүжилтийг баталгаажуулж, 1,700,000.0 мян.төгрөгийг гүйцэтгэгч компаниудад санхүүжилт хийгдсэн.Үүнд:

1.1.3.1.Хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажлын гэрээний дүн 1,550,011.0 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 1,240,008.8 мян.төгрөгийн ажлын гүйцэтгэл 80%

1.1.3.2.Сэлбэг, аж ахуйн агуулахын барилга угсралтын ажлын гэрээний нийт дүн 300,600.4 мян. төгрөг олгогдсон санхүүжилт 255,510.4 мян. төгрөг, ажлын гүйцэтгэл 75%

1.1.3.3.Уурын зуухны барилга угсралтын ажлын гэрээний нийт дүн 540,699.5 мян. төгрөг олгогдсон санхүүжилт 348,544.3 мян төгрөг ажлын гүйцэтгэл 70%

1.1.3.4.Шатахуун түгээх станцын барилга угсралтын ажлын гэрээний нийт дүн 184,000.0мян.төгрөг олгогдсон санхүүжилт 165,600.5 мян. төгрөг ажлын гүйцэтгэл 90%

1.1.3.5.Тос тосолгооны агуулахын барилгын ажлын гэрээний нийт дүн 311,879.5 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 210,511.0 мян. төгрөг ажлын гүйцэтгэл 50%

1.1.3.6.Дулаан гражийн барилга угсралтын багц 1 ажлын гэрээний дүн 3,855,451.3 мян.төгрөг, олгогдсон санхүүжилт 1,604,101.2 мян.төгрөг ажлын гүйцэтгэл 60%

1.1.3.7.Дулаан гражийн барилга угсралтын багц 2 ажлын гэрээний дүн 3,855,451.3 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 900,000.0 мян төгрөг ажлын гүйцэтгэл 45%

1.1.3.8.Дулаан гражийн барилга угсралтын багц 1 ажлын гэрээний дүн 3,855,451.3 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 1,604,101.2 мян.төгрөг ажлын гүйцэтгэл 60%

1.1.3.9.Ногоон байгууламж, зам талбайн барилгын ажлын гэрээний дүн 1,651,731.6 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 650,000.0 мян.төгрөг ажлын гүйцэтгэл 45%

1.1.3.10.Автобус паркийн харуулын байр, хашаа, дэд бүтцийн ажлын гэрээний дүн 1,651,731.6 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 650,000.0 мян.төгрөг ажлын гүйцэтгэл 90%

1.1.3.11.Угаах цех, кузов засварын барилгын ажлын гэрээний дүн 2,274,432.6 мян.төгрөг олгогдсон санхүүжилт 1,295,696.7мян. төгрөг ажлын гүйцэтгэл 90%

1.1.3.12.Цахилгаан хангамжийн ажлын гэрээний нийт дүн 1,246,595.3 мян.төгрөг, олгогдсон санхүүжилт 1,043,528.9 мян.төгрөг ажлын гүйцэтгэл 65% бөгөөд 2019-2021 оны нийт ажлын гүйцэтгэл 40%, 2022 онд 25%-аар өсөж нийт барилга угсралтын ажлын явц өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15%-аар өссөн үзүүлэлттэй. Хэрэгжилт 65%

Хүрсэн үр дүн:"Нийтийн тээврийн автобус бааз барих" төслийн ажлууд 2021 оны мөн үеэс 15%-иар өссөн үзүүлэлттэй.Нийт ажлын гүйцэтгэл 65% байна.

Нэгдүгээр бүлгийн хэрэгжилтийн дундаж хувь-82,5%

ХОЁРДУГААР БҮЛЭГ:ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Тусгагдсан зорилт:2.1.Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Дотоод хяналт, шалгалтын хэлтсээс хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-т заасан аргачлалыг баримтлан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, үнэлгээ хийсэн. Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг Даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавраас өгсөн нийт 36 шийдвэрийн 44 заалт тус үйлдвэрийн газарт "Бүрэн хэрэгжиж" гэж дүгнэсэн.Хэрэгжилт 99,5%

Хүрсэн үр дүн:Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

2.1.1.2022 онд хэрэгжүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан

Хүснэгт 1.Тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Д/д	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Хувь
1.Монгол Улсын хууль				
1	20	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996.05.27	Үйлдвэрийн газрын дарга өөрт олгогдсон эрхийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгон үндсэн чиглэлээр (А) 66, хүний нөөцийн чиглэлээр (Б) 645 тушаал гарган хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.	100%
2	1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль 2005.12.01	Үйлдвэрийн газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан иргэний гүйлгээнд оролцож нээлттэй тендер 27 зарлахаас 16 нээлттэй тендерийг цахимаар зарлан үр дүн гарч 13 гэрээ байгуулагдаж, цуцлагдсан 9 байна.	100%
3	122.1	Хөдөлмөрийн тухай хууль 2021.07.02	2022 оны А/08 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам", А/09 дүгээр тушаалаар "Ажил албан тушаалын тодорхойлолт"-ыг баталж нийт 312 ажилтанд танилцуулан хөдөлмөрийн гэрээ, нууцын гэрээ, эд хөрөнгийн гэрээ байгуулсан.	100%
4	154		2022 оны А/48 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс байгуулах тухай", А/51 дүгээр тушаалаар "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм батлах тухай" тушаалыг гарган хэрэгжүүлэн ажилласан.	
5	3.1.3	Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.29	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган хэмнэлтийн горимд шилжин тэвчиж болох бүх зардлыг танан нийт 1,139,500,000 (нэг тэр бум нэг зуун гучин есөн сая таван зуун мянган) төгрөгийн хэмнэлт хийсэн.	98,8%
6	5.1		Үйлдвэрийн газрын үйл ажиллагаа хариуцсан дэд дарга, ашиглалт хариуцсан дэд дарга нарыг чөлөөлсөн.	
	10	Автотээврийн тухай хууль	Тээвэрлэгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж тээврийн хэрэгсэл зорчиход саадгүй	100%

**"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

7		1999.06.04	байлгах үүднээс авто замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган уламжилж, тээврийн хөлс төлөлтөд хяналт тавих, иргэдийг цахим төлбөрийн карт руу шилжүүлэн, нийгмийн хэв журмыг сахиулан ажилласан. Нийтийн тээврийн автобусыг жолоодох D ангилалтай, D мэргэшсэн үнэмлэхтэй мэргэжлийн 158 жолоочийг шугамын үйлчилгээнд 2 ээлжээр ажиллуулж иргэдэд үйлчилсэн.	
8	16.1	Жолоочийн даатгалын тухай 2011.10.06	Нийтийн тээврийн автобусны жолооч нь хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад зам, тээврийн осол гаргаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөрийг хуулийн дагуу төлж байна. 78,562,325 (далан найман сая таван зуун жаран хоёр мянга гурван зуун хорин тав) төгрөгийг хохирол барагдуулсан.	100%
9		Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай 1995.04.17	Үйлдвэрийн газарт нийт 426 өргөдөл, гомдол үүнээс ажилд орох-173, ажлаас чөлөөлөгдсөн-113, судлагдаж байгаа-1, цалинтай чөлөө-17, тэтгэмж-29, чөлөө хүссэн-93 иргэний өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн.	100%
10	6.1.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2021.12.17	Хуулийн хэрэгжилтийг ханган үйлдвэрийн газрын төсөв, гүйцэтгэл, бүтэц орон тоо, 5 сая төгрөгөөс дээш худалдан авах ажил үйлчилгээ, аудитын тайлан, дүгнэлт, тендерийн ерөнхий мэдээллийг сар бүрийн 05-ны өдрийн дотор шилэн дансны shilendans.gov.mn сайтад 117 мэдээлэл оруулахаас 112 мэдээллийг хугацаанд нь оруулж 5 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн. Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл -2, 5 саяас дээш гүйлгээний дүн мэдээ -3 тус тус хоцроосон.	95,7%
11	15.1	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2021.12.17	Нийт 56 албан хаагчийн "биометрик мэдээлэл" буюу хурууны хээг устгах ажлыг зохион байгуулж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн цагийн бүртгэлийг өөрчилсөн.	100%
Хэрэгжилт-99,6%				
Ерөнхийлөгчийн зарлиг				
12	1	Дугаар 58 Засгийн газарт чиглэл өгөх тухай (Тэрбум мод) 2021.10.04	Нийслэлийн Сонгонхайрхан дүүргийн 24 дүгээр хороо "Бумбат рашаан"-д 2021 онд 100 ширхэг мод, 2022 онд 10 ширхэг мод нийт 200 модыг арчлан хамгаалсан.	100%
Хэрэгжилт-100%				
Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар				
13	1.1	Дугаар 06 Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн сурталчлан таниулах тухай 2022.07.05	"Алсын хараа -2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилтыг инженер техникийн болон захиргааны нийт 45 ажилчдад сурталчлан танилцуулсан.	100%
Хэрэгжилт-100 хувь				
Засгийн газрын тогтоол				

**"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

14	4.1, 4.2	Дугаар 311 "Нийтлэг журам батлах тухай (аанб-ын дотоод хяналт шалгалт)" 2011.11.09	Үйлдвэрийн газрын даргын баталсан төлөвлөгөөний дагуу удирдамжтай 6, төлөвлөгөөт 19, төлөвлөгөөт бус 3, онлайн камераар хийсэн стандарт мөрдөлтийн шалгалт 6 нийт 34 хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг газрын даргад танилцуулан холбогдох хэлтэст, зөрчлийн хуудас, зөвлөмжийг	100%
15	1.7, 18	Дугаар 43 Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2018.02.06	Нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн түлшний хэрэглээнд үе шаттай нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд цахилгаан нийтийн тээврийн автобус 36, 2022 онд 2 давхар цахилгаан автобус 10, дан цахилгаан автобус 1 нийт 47 цахилгаан нийтийн тээврийн автобуснуудыг шугамын үйлчилгээнд явуулсан.	100%
16	1.3	Дугаар 1 Коронавируст халдвар (Ковид19)-ын цар тархалтын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай 2022.01.05	Байгууллагын нийт ажилтнууддаа Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тархалтын түвшинд хувь хүн, гэр бүлд болон хуулийн этгээдэд чиглэсэн үйл ажиллагааны горимыг танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. Байгууллагын ажлын байрыг ариутгах ажлыг "Дөлгөөн хангайн түшиг" ХХК-тай гэрээ байгуулан тайлант хугацаанд 4 удаа зохион байгуулсан. Шугамын үйлчилгээний болон сургуулийн хүүхдийн автобус нийт 91 автобусыг улиралд нэг удаа, тайлант хугацаанд 4 удаа ариутгасан. Тайлант хугацаанд давхардсан тоогоор 762 ширхэг витамин С, аньс, нэрс, чацаргана, аарц чанаж засвар үйлчилгээний ажилчид, ерөнхий механикийн хэсгийн ажилчдад олгосон. Үйлдвэрийн газрын 364 ажилтанд давхардсан тоогоор 7306 ширхэг амны хаалт, 91 автобусанд 50 мг гар ариутгагч 200 ширхэг, 25мг гар ариутгагч засварчдад 49 ширхгийг олгосон. ПСР шинжилгээнд 32 ажилтанг хамруулсан. Ажилчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, 315 ажилтан хамрагдахаас 220 ажилтан буюу 69,8 % хамрагдсан. 95 ажилтан ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй байсан.	90%

**"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

17	1	Дугаар 201 "Журам батлах тухай" 2022.05.18	Шилэн дансны вэб сайтад сар бүрийн 05-ны өдрийн дотор дараах мэдээллийг байршуулж байна: - 5 сая төгрөгөөс дээш худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ - Худалдан авах ажиллагааны тайлан - Тендерийн ерөнхий мэдээлэл - Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө - Худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөө - Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын зорилтот, түвшин, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан - Дараа жилийн төсвийн төслийн мэдээлэл - Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт - Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан - Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ - Санхүүгийн тайлан - Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт - Өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр - Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан - Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт - Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан Тайлант хугацаанд нийт 117 мэдээлэл оруулахаас 112 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан.	98 %
18	1.1.	Дугаар 203 "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2022.05.25	Үйлдвэрийн газрын үйл ажиллагаа хариуцсан дэд дарга, ашиглалт хариуцсан дэд даргыг чөлөөлж 24,795,400 (хорин дөрвөн сая долоон зуун ерэн таван мянга дөрвөн зуу) төгрөгийн хэмнэлт гаргасан.	100%
19	1	Дугаар 64 "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай" 2022.02.22	Үйлдвэрийн газрын эд хөрөнгийн тооллогыг 2021 оны жилийн эцсийн байдлаар улсын үзлэг, тооллого хийж дуусган, мэдээллийг нэгтгэн Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсэн.	100%
Хэсгийн дундаж:99%				
Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол				
20	1	Дугаар 41 "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын нийгмийн даатгалын өрийг шийдвэрлэх тухай" 2022.05.30	Үйлдвэрийн газрын 2018 оноос хойш хуримтлагдсан Нийгмийн даатгалын өр төлбөрөөс урьдчилгаа төлбөрөөр санхүүжиж 1,600,000,000 (нэг тэрбум зургаан зуун сая) төгрөгийг барагдуулсан.	100%
	2	Дугаар 79		100%

**"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

21		Машин цагийн зардлын тарифыг шинэчлэн батлах тухай 2022.09.07	Машин цагийн зардлын тариф шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нийтийн тээврийн автобусны жолоочийн 1 цагийн цалин хөлсийг 33-40 хувиар нэмэгдүүлсэн.	
Хэсгийн дундаж: 100%				
Нийслэлийн Засаг даргын захирамж				
22	3	Дугаар А/01 2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарлах тухай 2022.01.03	2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарлах тухай захирамжийн хүрээнд тус байгууллагаас хийж хэрэгжүүлэх ажлын саналыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/50 дугаар албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн.	100%
23	1	Дугаар А/44 Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай 2022.01.18	Нийслэл, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хүүхдийн сургуулийн 5 тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөд бүртгэн авсан.	100%
24	1	Дугаар А/54 "Улаанбаатар Марафон" олон улсын гүйлт зохион байгуулах тухай 2022.04.21	Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн арга хэмжээнд үйлдвэрийн газрын 23 ажилтан төлөөлөн идэвхитэй оролцсон.	100%
25	1,2,3	Дугаар А/578 "Ажлын хэсэг байгуулах тухай" 2022.04.27	Нийт ажилчдын биометрик мэдээлэл болох хурууны хээг устган тайлан мэдээг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/162 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газар хүргүүлсэн.	100%
26	2	Дугаар А/598 "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2021 оны ажлыг дүгнэх тухай" 2022.05.02	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас ирүүлсэн 10 дугаар зөвлөмжийн дагуу 2022 оны ажлын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, тайлан мэдээг холбогдох хэлтэст хүргүүлсэн.	100%
27	1, 2	Дугаар А/768 "Нийслэл хотын ялгамж чанарыг илтгэх тэмдгийг батлах тухай" 2022.06.03	2022 онд парк шинэчлэлтийн ажлын хүрээнд шинээр орж ирсэн 2 давхар 10 автобусан дээр Нийслэл хотын ялгамж чанарыг илтгэх тэмдгийг байршуулан олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.	100%
28	1	Дугаар А/789 "Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" 2022.06.09	Өмчийн харилцааны газарт 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/244 дүгээр албан бичгээр ашиглалтад байдаг 4 тээврийн хэрэгслийн мэдээллийг хүргүүлсэн.	100%
29	3	Дугаар А/851 "Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай" 2022.06.23	Нийтийн тээврийн үйлчилгээний стандарт MNS 5012:2011 стандартын хүрээнд: -Нийтийн тээврийн автобусны жолоочийн ажлын хувцсыг стандартад нийцүүлэн хийлгэж 161 жолоочийг ажлын хувцсаар бүрэн хангасан. -90 тээврийн хэрэгслийн зорчигчдын суудлыг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн, нялх хүүхэдтэй эхчүүдэд зориулан өнгөөр ялгаж, тусгай зориулалтын тэмдэглэгээ байршуулсан. -Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа 91 тээврийн хэрэгслээс 47 цахилгаан автобусны хаягийг урсдаг лед дэлгэц, 44 дизель хөдөлгүүртэй том болон дунд оврын нийтийн тээврийн автобусны хаягийг хэвлэмэл болгож, хаягжилтыг бүрэн хийж гүйцэтгэсэн.	100%
30	1	Дугаар А/912 "Нэг тархи-Нэгдсэн систем" төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах тухай	2022 онд парк шинэчлэлээр орж ирсэн 2 давхар 10 автобусыг картын нэгдсэн системд холбож, бүрэн камержуулсан.	100%

**“Зорчигч тээвэр гурав”ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

		2022.07.01		
31	2	Дугаар А/917 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын нийгмийн даатгалын өрийг шийдвэрлэх тухай 2022.07.01	Үйлдвэрийн газрын 2018 оноос хойш хуримтлагдсан Нийгмийн даатгалын өр төлбөрөөс уридчилгаа төлбөрөөр санхүүжиж 1,600,000,000 (нэг тэрбум зургаан зуун сая) төгрөгийг барагдуулсан.	100%
32	1,3	Дугаар А/1038 Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай	Нийтийн тээврийн үйлчилгээний 2 давхар 10 автобус 1 давхар 1 автобусыг үндсэн хөрөнгөд бүртгэн авсан.	100%
33		Дугаар А/1106 Журам шинэчлэн батлах тухай	2023 оноос хэрэгжүүлэн ажиллана.	
34	3.1	Дугаар А/1206 “Автомашингүй өдөр” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай 2022.09.16	Үйлдвэрийн газрын үйлчилж буй нийтийн тээврийн үйлчилгээний Ч:1” 5 шар-Офицеруудын ордон”, Ч:29 “Сэлбэ амралт-Вокзал”, Ч:59 “Офицеруудын ордон-Ханын материал”, Ч:72 “Богд хан амралт-Хөгжим бүжгийн коллеж” чиглэлд маршрутын өөрчлөлт орсон.	100%
35	2	Дугаар А/1224 Машин цагийн зардлын задаргааг шинэчлэн батлах тухай 2022.09.19	Машин цагийн зардал шинэчлэн баталсантай холбогдуулан Нийтийн тээврийн автобусны жолоочийн 1 цагийн хөлсийг 30-40 хувиар нэмсэн.	100%
36	2.6	Дугаар А/1357 “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 2022.10.21	“Таван толгой түлш” ХХК-тай шахмал түлш нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж, үйлдвэрийн газрын уурын зууханд хэрэглэх 80 т шахмал түлш ашиглаж байна.	100%
Хэрэгжилт:100%				
Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар.				
	1.1	Дугаар 01 “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны жилийн эцсийн тайлан. 2022.01.31	Нийт 426 өргөдөл, гомдол үүнээс ажилд орох-173, ажлаас чөлөөлөгдсөн-113, судлагдаж байгаа-1, цалинтай чөлөө-17, тэтгэмж-29, чөлөө хүссэн-93 иргэний өргөдөл, гомдлыг цаг тухайд нь хянан шийдвэрлэж хэрэгжилтийн хугацаа нийт 05 цаг 07 минут зарцуулсан.	100%
	1	Дугаар 11 “Хотын иргэний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийн явцын талаар 2022.07.06	“Хотын иргэний жил”-ийн хүрээнд Стандартад нийцсэн нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг хийж 2 давхар 10 цахилгаан автобусаар иргэдийн ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.	100%
	1	Дугаар 16 Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2022 оны 3-р улирлын тайлан. 2022.10.07	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг өөрийн https://bus3.ub.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан.	100%

**“Зорчигч тээвэр гурав”ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

	2	Дугаар 17 Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай А/851 дугаар захирамжийн биелэлт 2022.10.18	Нийтийн тээврийн үйлчилгээний стандарт MNS 5012:2011 стандартын хүрээнд: -Нийтийн тээврийн автобусны жолоочийн ажлын хувцсыг стандартад нийцүүлэн 161 жолоочид хүлээлгэн өгсөн. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа 91 тээврийн хэрэгслээс 47 цахилгаан автобусны хаягийг урсдаг лед, 44 дизель хөдөлгүүртэй том болон дунд оврын нийтийн тээврийн автобусны хаягийг хэвлэмэл болгож хаягжилтыг бүрэн хийж гүйцэтгэсэн	100%
	1	Дугаар 20 “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц 2022.11.22	Нийслэлийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Тээвэр логистик 6.3.14-ийн хэрэгжүүлэх арга хэмжээ 338 дугаар ажил 100%, 340 дүгээр ажил 100% тай хэрэгжсэн.	100 %
Хэрэгжилт-100%				
Хүрсэн үр дүн:Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг “Бүрэн хэрэгжүүлж” 99,5%хувь				

**ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН БАЙГУУЛЛАГЫН
ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:**

Тусгагдсан зорилт: 3.1.1. Нийтийн тээврийн газартай ажил үйлчилгээний гэрээг байгуулан, сар бүр дүгнүүлж, гэрээний үүргийн биелэлтийг тогтмол 95%-иар биелүүлж ажиллах:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Нийтийн тээврийн газраас батлагдсан цаг, график замналын дагуу үндсэн 12 чиглэлд ажлын өдөр 70 гаралт, амралтын өдөр 67 гаралт гаргаж, зорчигчдод үйлчилсэн. Нийтийн тээврийн газартай байгуулсан "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний биелэлтийг 2021 он эхний 3 дугаар улирлын байдлаар 92,3%, 2022 оны мөн үед 92,7%-тай. Гэрээний үүргийн биелэлт зорилтод түвшинд хүрээгүй шалтгаан нь зориулалтын гарааш байхгүй, техникийн эвдрэл их гарч, сэлбэг материал хомсдолтой, нийлүүлэлт удаан, мэргэшсэн жолоочийн нөөц дутагдал зэрэг нөлөөлсөн.

Нийтийн тээврийн газартай нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх гэрээг сар бүр дүгнүүлэн ажилласан. Үүнд:

Хүснэгт 2. 2021, 2022 оны гэрээний үүргийн биелэлт (эхний 3 дугаар улирлын байдлаар)

№	Сар	2021 он гэрээ дүгнэлт /хувь/	Үнэлгээ	2022 он гэрээ дүгнэлт /хувь/	Үнэлгээ
1	1-р сар	96.7	Бүрэн хангалттай	91.4	Бүрэн хангалттай
2	2-р сар	97.3	Бүрэн хангалттай	92.3	Бүрэн хангалттай
3	3-р сар	98	Бүрэн хангалттай	91.1	Бүрэн хангалттай
4	4-р сар	97.8	Бүрэн хангалттай	92.9	Бүрэн хангалттай
5	5-р сар	93.5	Бүрэн хангалттай	93.4	Бүрэн хангалттай
6	6-р сар	96.5	Бүрэн хангалттай	92.7	Бүрэн хангалттай
7	7-р сар	94.7	Бүрэн хангалттай	91.7	Бүрэн хангалттай
8	8-р сар	93	Бүрэн хангалттай	93.7	Бүрэн хангалттай
9	9-р сар	95	Бүрэн хангалттай	95.5	Бүрэн хангалттай
10	10-р сар	94.4	Бүрэн хангалттай	95.6	Бүрэн хангалттай
11	11-р сар	92.2	Бүрэн хангалттай	97.5	Бүрэн хангалттай
12	12-р сар	94.6	Бүрэн хангалттай		Дүгнэгдээгүй
Нийт		95.1	Хангалттай	93.4	

Хүрсэн үр дүн: Гэрээний үүргийн биелэлт 2022 оны байдлаар нийт 93.4 хувь байна. Хэрэгжилт 93,4%

Тусгагдсан зорилт: 3.1.2. Нийтийн тээврийн шугамын үйлчилгээний цаг, рейсийн алдагдалгүй, смартын ТВОХ-ийн зөрчлийг бууруулж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.2.1. 2021 оны байдлаар нийтийн тээврийн нэг өдрийн гаралт 65 байсан ба 253421:18 шугам цагийн даалгавар гүйцэтгэхээс 233203:08 цаг 92,02% гүйцэтгэж, 2022 оны байдлаар нийтийн тээврийн нэг өдрийн гаралт 70 шугам цагийн 307077:57 даалгавар гүйцэтгэхээс 274574:48 цаг гүйцэтгэж 89,4% гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Цагийн түвшин өмнөх оны мөн үеийнхээс буусан. Цагийн түвшин буусан нь гаралтын тоо 5-аар нэмэгдсэн. 2009 он, 2015 онд үйлдвэрлэгдсэн нийтийн тээврийн автобуснуудын насжилт дуусч, сэлбэг материалын хомсдолд орж техникийн бэлэн байдал хангагдаагүй мөн мэргэшсэн жолоочийн дутагдал зэрэг нөлөөлсөн.

Хүснэгт 3. Цагийн түвшин (сараар)

Сар	Даалгавар	Гүйцэтгэл	Хувь
1 дүгээр сар	26851:20	23502:21	91.4
2 дугаар сар	24297:05	20993:24	92.3


**"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

3 дугаар сар	27056:27	24167:35	91.1
4 дүгээр сар	26243:57	24141:56	92.9
5 дугаар сар	27203:38	24434:20	93.4
6 дугаар сар	28111:11	24653:43	92.7
7 дугаар сар	29238:14	25939:36	91.7
8 дугаар сар	30132:14	29916:01	93.7
9 дүгээр сар	28971:05	26507:43	95.5
10 дугаар сар	29493:35	26906:15	95.6
11 дүгээр сар	29493:35	26906:15	97.5
12 дугаар сар	28504:44	25813:32	дүгнэгдээгүй

3.1.1.2.2021 онд 143317,5 рейс гүйцэтгэхээс 119598 буюу 83,4% гүйцэтгэсэн. 2022 онд 174299 рейс гүйцэтгэхээс 122077,5 буюу 70,3%-тай гүйцэтгэж 13,1%-иар буурсан нь техникийн бэлэн бус байдал, замын ачаалал ихэссэнтэй холбоотой байна. ТВОХ-ийн зөрчилтэй цаг 2021 онд 390:59 цаг бүртгэгдсэн бол 2022 онд 160:34 цаг бүртгэгдэж, 230:25 цагаар багассан үзүүлэлттэй. Хэрэгжилт 89,4%

Хүрсэн үр дүн:ТВОХ-ийн зөрчилтэй цагийг 41,5%-иар бууруулж ажилласан.

График 1. 2021, 2022 оны ТВОХ-ын зөрчлийн харьцуулалт



Тусгагдсан зорилт:3.1.3.Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулж, санал гомдлыг бууруулж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Нийтийн тээврийн үйлчилгээтэй санал гомдол 2021 онд 16, 2022 онд 27 бүртгэгдэж 11 гомдлоор өссөн.

Хүснэгт 4. Санал гомдол

Д/д	Санал гомдлын төрөл	Санал гомдлын тоо	Тайлбар
1	Жолоочтой холбоотой гомдол	2	Гарааш 3-045 дугаартай автобусны жолооч Д.Отгонтуяа зорчигчын гар хавчсан зөрчил гаргаж нийтийн тээврийн байцаагч Ш.Бямбаа дуудаж уулзан гомдол гаргагчтай холбогдож гомдлыг шийдвэрлэсэн. Гарааш 3-147 дугаартай автобусны жолооч Э.Цогтбилэг бэлэн мөнгө авсан гомдол ирж байцаагч Д.Долгорсүрэн 25000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн. Гомдлыг хуулийн хугацаанд 100% барагдуулсан.
2	Тээврийн хэрэгслийн өнгө үзэмжтэй холбоотой гомдол	1	
3	Эх авах цагийг урагшлуулах санал, удаан хүлээлгэсэн гомдол	9	
4	Зогсоолд зогсоогүй зөрчил	13	
5	Эргэлтийн хугацааг богиносгох санал	2	

Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Гомдлыг хуулийн хугацаанд 100% барагдуулсан.

График 2. 2021, 2022 оны санал гомдлын харьцуулалт



Тусгагдсан зорилт:3.1.4.Тээврийн хэрэгслийн жолоочоос шалтгаалсан ашиглалтын саатал, зам тээврийн осол зөрчлийг бууруулж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.4.1.Тээврийн хэрэгслийн ашиглалтын саатал 2022 онд 5515:54 цаг гарсан. Үүнээс дугуй хагарч зогссон 3345:15, түлш дууссан болон зам тээврийн осол, бусад саатал 969:45 цаг, жолоочоос шалтгаалсан 1200:54 цаг гарсан. Ашиглалтын сааталтай цаг өссөн нь тээврийн хэрэгслийн дугуйн эвдрэл их гарснаас шалтгаалан өссөн.

Хүрсэн үр дүн:Жолоочоос шалтгаалсан ашиглалтын цаг 2021 онд 1942 цаг, 2022 онд 1200:54 цаг бүртгэгдэж 742:54 цагаар буурсан.

3.1.4.2.Зам тээврийн осол 2021 онд 205 бүртгэгдэж, 82 осол манай жолоочийн буруутай үйлдлээс болсон.2022 онд 194 зам тээврийн осол, зөрчил бүртгэгдсэнээс манай жолоочийн буруутай 79 осол. Осол гаргасан, өртсөн жолооч нарт давтан зааварчилга өгсөн.

Хэрэгжилт 70%

Хүрсэн үр дүн:Зам тээврийн ослын тоо 11-ээр буурсан.

Тусгагдсан зорилт:3.1.5.Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг техникийн бэлэн байдалд тогтмол үзлэг хийж, илэрсэн эвдрэл гэмтлүүдийг богино хугацаанд чанартай засварлан техникийн бэлэн байдлын коэффициентыг 82.5 %-иас бууруулахгүй ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Дансаар 132 тээврийн хэрэгсэлтэй, үүнээс сэлбэг материалын олдоц тааруу хомсдол үүссэнээс болж 23 автобус удаан зогссон, ашиглалт дууссан 26 автобусыг актлах хүсэлт өгч бүрэн зогсоож, бэлэн тээврийн хэрэгсэл 83. Техникийн бэлэн байдалд үзлэг шалгалтыг тогтмол хийж, тайлант жилд давхардсан тоогоор 2135 автобусны тормос чангалах, гэрэл дохио сольж, шугамын үйлчилгээнд ажиллуулсан.Үүнээс бүрэн ээлж хийсэн-17, хуучин ком хөдөлгүүр сольсон-10, давхардсан тоогоор 55 автобусанд засвар үйлчилгээ хийсэн.

Техникийн саатал 2021 онд 10576:40 цаг, 2022 онд 12338:33 цаг гарч, 1762:08 цагаар өссөн.Техникийн бэлэн байдал 2021 онд 65,1%, 2022 онд 64,5%-ийн 0,6%-аар өссөн. Техникийн бэлэн байдлын коэффициентыг 18%-аар тасалдуулсан. Хэрэгжилт 65,4%

Зорилтод түвшиндээ хүрээгүй шалтгаан: Дэвү, каунти маркын автобуснуудын нормын хугацаа дууссан, сэлбэг олдоц тааруу зэрэг нөлөөлсөн.

Тусгагдсан зорилт:3.1.6.Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг хавар, намрын техникийн улсын үзлэг оношилгоонд жилд 2 удаа хуваарийн дагуу хамруулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 2022 оны хавар, намрын тээврийн хэрэгслийн хяналт шалгалтын үзлэгт давхардсан тоогоор нийт 97 тээврийн хэрэгслийг бүрэн хамрагдаж тэнцсэн байна. Нийтийн тээврийн шугамын үйлчилгээг тасалдуулахгүйгээр ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Улсын техникийн үзлэгт тээврийн хэрэгслүүдээ хугацаанд нь бүрэн хамруулсан.

Тусгагдсан зорилт: 3.1.7. Шугамын үйлчилгээний тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, угаалга, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвших.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.7.1. Шугамын үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс 4:25 тоосгоны үйлдвэрийн эцэс, 4:29 Сэлбэ амралтын эцэс, ХО:5 Налайхын эцэс гэсэн гурван чиглэлийн эцэст дундын цэвэрлэгээ хийх цэг байгуулан өдөрт нэг автобусанд 2 удаа чийгтэй цэвэрлэгээг хийдэг. Үйлдвэрийн газарт оройн буултаар ирж буй автобусанд гадна угаалгыг 1 хүн, дотор цэвэрлэгээг 14 хүн хоёр ээлжээр ажиллаж цэвэрлэж байна. Давхардсан тоогоор өдөрт дунджаар 78, тайлант хугацаанд давхардсан тоогоор 25740 тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ хийсэн

Зураг 2. Автобусны угаалга, цэвэрлэгээ



3.1.7.2. Газрын даргын 2022 оны А/55 дугаар тушаалаар захиргааны ажилчдад 1-2 тээврийн хэрэгслийг хариуцан ажиллах хуваарь батлагдаж, 14 хоног тутам автобуснуудад цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулан ажилласан.

3.1.7.3. 2022 онд "Өнө мөнх тэнтэр" ХХК мэргэжлийн ариутгалын компанитай гэрээ байгуулан автобусны ариутгалыг 14 хоног тутам, объектын ариутгалыг сард 1 удаа хийлгэсэн. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн: Шугамын үйлчилгээний тээврийн хэрэгслийн цэвэрлэгээний чанар сайжирсан

Тусгагдсан зорилт:3.1.8.Батлагдсан цаг графикийн дагуу нийтийн тээврийн шугамын үйлчилгээний өглөөний эх авалт, оройн буултыг бүрэн биелүүлж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:2021 үндсэн 14 чиглэлд өглөөний эх авалтыг 92,2%, оройн буултыг 94,0% биелүүлэн ажилласан. 2022 онд 20539 эх авалт гаргахаас 19505 эх авалт хийж, 2014:41 цаг 94,9%-ийн гүйцэтгэлтэй, оройн буулт 12119 хийхээс 11466 хийж 1248:05 цаг 94,6%-ын гүйцэтгэлтэй ажилласан. Хэрэгжилт 94,9%

Зорилтод түвшинд хүрээгүй шалтгаан:Эх авалт, оройн буулт тасарч байгаа нь ашиглалтын хугацаа хэтэрсэн техникийн эвдрэл, сэлбэг материалын хомсдол зэргээс шалтгаалсан.

Тусгагдсан зорилт:3.1.9 Тээврийн хэрэгслийг чиглэлийн хаяг, замнал, гаралтын дугаар, рейс цагийн графикаар бүрэн хангаж, шугамын үйлчилгээнд гаргах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Нийтийн тээврийн шугамын үйлчилгээнд ажиллаж байгаа том оврын 47 цахилгаан автобус лед хаягтай. Хаягны бүрэн байдлыг мэдээлэл технологийн инженер Б.Ганболд хариуцан ажилладаг. Каунти, Daewoo маркын 45 автобусны хаягийг "Төгс смарт линк" ХХК-тай хамтран ажиллаж 3,304.0 мян.төгрөгийн өртөг бүхий хулдаасан болон хөөсөн хаягаар шинэчилсэн.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Тээврийн хэрэгслийг чиглэлийн хаягаар бүрэн хангаж шугамын үйлчилгээнд ажиллуулсан.

Тусгагдсан зорилт:3.1.10.Жолооч нарыг стандарт шаардлагын дагуу ажлын хувцсаар хангаж, шугамын үйлчилгээнд тогтмол өмсүүлж хэвшүүлэх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Нийтийн тээврийн үйлчилгээний 150 жолоочийг 69,000.0 төгрөгийн өртөг бүхий өвлийн хувцсаар хангасан. Ажлын хувцас (хантааз) 161 захиалж 145 жолоочид олгож, өмсүүлж хэвшүүлсэн.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Нийтийн тээврийн жолооч нарыг бүрэн ажлын хувцсаар хангасан.

Тусгагдсан зорилт:3.1.11.Шалгагч нарыг хуваарийн дагуу шугамын автобусанд зорчигч нарт зөвлөгөө өгөх, хяналт тавьж ажиллуулах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.11.1. Үйлдвэрийн газрын даргын баталсан 01 дүгээр удирдамжийн дагуу үйлчилж буй 14 чиглэлд орлогын доод хязгаар тогтоох ажлын зураг авалтыг зохион байгуулж ажилласан. Ажлын үр дүн 77195 зорчигч зорчсноос картын орлого 41209 төгрөг, хөнгөлөлтэй зорчигчид (ахмад, оюутан, хөнгөлттэй зорчигч, цагдаа, донор, дамжин суулт) 35986 буюу 47%-ийг эзэлсэн дүгнэлт гарсан. Дүгнэлтийг Нийтийн тээврийн газарт хүргүүлсэн.

3.1.11.2.Тайлант хугацаанд давхардсан тоогоор 105 шалгагч хуваарийн дагуу шугамын үйлчилгээнд зорчигчдод зөвлөгөө өгч, 20 шалгагч пос машинаар карт борлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Нийтийн тээврийн тээврийн үйлчилгээнд шалгагч нарыг хуваарийн дагуу хяналтаар ажиллуулсан.

Тусгагдсан зорилт:3.1.12.Тээврийн хэрэгслийн ТҮ I,II-ыг батлагдсан хуваарийн дагуу тогтмол хийж, шаардлагатай үед тодотголыг сар бүрийн 20-ны дотор хийж, батлуулах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Батлуулсан хуваарийн дагуу сар бүр ТҮ/1-ээр 37-38 автобус, ТҮ/2-оор 40-41 автобусыг үйлчилгээнд оруулж давхардсан тоогоор ТҮ-1ээр 369, ТҮ/2-оор 416 автобусанд үйлчилгээ хийсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг ТҮ/1-ээр 76 автобус, ТҮ/2-оор 85 автобус давхардсан тоогоор ТҮ/1-ээр 574, ТҮ/2-оор 604 автобусаар илүү хийж төлөвлөгөөнөөс давуулан биелүүлсэн.

Тусгагдсан зорилт: 3.1.13. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт хөдлөх бүрэлдэхүүний урсгал засварын ажил зохион байгуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тайлант онд урсгал засвар буюу их засварыг давхардсан тоогоор 2890 автобусанд хийсэн. Өдөрт 14-15, сард давхардсан тоогоор 420-450, кузов засварт 289, жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор нийт 4793 автобус урсгал засвар хийсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Техникийн бэлэн байдлыг хангаж ажилласан.

Тусгагдсан зорилт: 3.1.14. Автобусны техникийн саатлыг 2021 оноос 50% -иар бууруулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Техникийн саатал 2021 онд 10576:40 цаг, 2022 онд 12338:33 цаг гарч, 1762:08 цагаар өссөн. Техникийн бэлэн байдал 2021 онд 65,1%, 2022 онд 64,5%-ийн 0,6%-иар өссөн. Хэрэгжилт 64,5%

Зорилтод түвшиндээ хүрээгүй шалтгаан: Шугам замын эвдрэлээс үүдэлтэй дунд оврын автобусны нум, шарнер, цапны пальц, амортизатор гэх мэт явах эд ангийн эвдрэл, Дэу маркийн автобусны 12 жилийн норм гүйлт дууссан, моторын их засвар зэргээс шалтгаалсан.

Тусгагдсан зорилт: 3.1.15. Нийт хөдлөх бүрэлдэхүүний гадна өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор кузов засварын ажлыг зохион байгуулах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 2022 онд төлөвлөгөөр 122 автобус кузов засвар хийхээс давхардсан тоогоор 289 автобусанд кузов засвар үйлчилгээ хийсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Автобусны гадна өнгө үзэмж сайжирсан.

Тусгагдсан зорилт: 3.1.16. 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжүүлж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.16.1. "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг батлуулж, 2022 оны 01/352 дугаар албан бичгээр Нийтийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

3.1.16.2. Үйлдвэрийн газрын даргын 2022 оны А/50 дугаар тушаалаар "Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах тухай" тушаал батлагдан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.

3.1.16.3. Тайлант хугацаанд сар бүр төлөвлөгөөний биелэлт, зарцуулсан мөнгөн дүнгийн хамт Нийтийн тээврийн газарт хүргүүлэн ажилласан. Хэрэгжилт 93%

Хүрсэн үр дүн: Өвөлжилтийн бэлтгэл ажлын шалгалтаар хангалттай үнэлгээтэй дүгнэгдсэн.

Хэсгийн дундаж үнэлгээ: 85,9

3.2.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ)

Тусгагдсан зорилт:3.2.1.УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ЗГ-ын тогтоол, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, НЗД-ын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Тайлант хугацаанд Монгол Улсын хууль-9, Ерөнхийлөгчийн зарлиг-1, Ерөнхий сайдын албан даалгавар-1,Засгийн газрын тогтоол- 6, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол-2, Нийслэлийн Засаг даргын захирамж-10, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл 5, нийт 34 шийдвэр, 48 зүйл заалтыг хяналтанд авч хэрэгжилтийн биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр НЗДТГ-т тайлагнасан. Хэрэгжилт-99,5%

Хүрсэн үр дүн:Хууль тогтоомжин хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлсэн.

Тусгагдсан зорилт:3.2.2.Нийслэлийн засаг даргаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, хэрэгжилтийн мэдээ тайланг хугацаанд нь НЗДТГ-т хүргүүлж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 123 үүрэг даалгаварын биелэлтийг 14 хоног тутам Ulaanbaatar.mn-д тайлагнасан.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлсэн.

Тусгагдсан зорилт:3.2.3.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн захиргааны албан хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг үнэн зөв, хуулийн хугацаанд хүргүүлж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.3.1.2022 онд захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн дарга, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, дотоод хяналт шалгалтын хэлтсийн дарга, техник технологийн хэлтсийн дарга, дотоод хяналт, шалгалтын хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч нар Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хүлээн авч бүртгэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасны дагуу Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан. Хэрэгжилт 100%

3.2.3.2.Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нийт биелэлтийн тайланг гаргаж НЗДТГ-т хүргүүлсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Холбогдох албан тушаалтнууд ХОМ-ийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн.

Тусгагдсан зорилт:3.2.4.Гамшгийн үед байгууллагад авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Байгууллагын хэмжээнд галын 3 сарааны бүрдлийг бүрдүүлж, холбогдох ажилтанд хүлээлгэж өгсөн. Заавар, самбар, тэмдэг тэмдэглээ, галын бүлгэмийн ажиллах заавар 3 ширхэг, гамшиг осол гал түймрээс урьдчилан сэргийлэх самбар 3 ширхэг, осол гарсан үеийн аврах гарцын схем самбар 3 ширхэг, галын аюулгүйн тэмдэгүүд 3 ширхэг тус тус байршуулсан. 40 ширхэг галын хор худалдан авч, 95 ширхэг галын хор цэнэглүүлсэн. Нийт 135 ширхэг галын хор бүрдүүлсэн. Хэрэгжилт 60%

Зорилтод түвшиндээ хүрээгүй шалтгаан: Гамшгийн үед байгууллагад авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулаагүй

Тусгагдсан зорилт: 3.2.5. Байгууллагын "Ажилтнуудын ёс зүйн дүрэм"-ийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.5.1. Үйлдвэрийн газрын хэмжээнд "Ажилтны ёс зүйн дүрэм"-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороонд 7 өргөдөл албан хаагчдаас ирж, 7 удаагийн хурал зохион байгуулж, асуудлыг шийдвэрлэн 3 асуудлыг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр санал хүргүүлэн, асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.

3.2.5.2. Газрын даргын 2022 оны А/08 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д, "Ажлын байрны дэг"-ийг тодорхойлон тусгаж үндсэн 315 ажилтан, шинээр ажилд орсон 65 ажилтанд танилцуулж, хэрэгжилтэд хяналт, тавьж ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Ажлын байрны дэг журам зөрчсөн ажилтан байхгүй.

Тусгагдсан зорилт: 3.2.6. Хөдөлмөрийн аюулгүй байдалд тавих үзлэг, шалгалт хийх, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, чанаржуулах ажлыг зохион байгуулах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.6.1. Үйлдвэрийн газрын хэмжээнд 23 нэр төрлийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан мөрдүүлж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтыг тайлант хугацаанд 24 удаа хийсэн.

3.2.6.2. Техникийн бүрэн бүтэн байдлын үзлэгийг сар бүр хийж илэрсэн зөрчлийг шуурхай хуралд мэдээлж, зөрчлийг арилгуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар 6 удаагийн сургалтыг зохион байгуулж 318 ажилтан хамрагдсан.

3.2.6.3. Ажлын байрны урьдчилсан зааварчилга 172 ажилтан, давтан зааварчилга давхардсан тоогоор нийтийн тээврийн автобусны жолооч-382, шалгагч-65, техник технологийн хэлтсийн урсгал засварын засварчид өдөр тутам, шалгах механик, сантехникийн засварчид, тоног төхөөрөмжийн засварчин, гагнуурчин, цахилгаанчин, мужаан, тэрэг тавигч нарт өдөр тутмын зааварчилгааг өдөр бүр-365, давтан зааварчилгааг инженер техникийн ажилчид, сард 1 удаа нийт-12 удаа өгч ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн Тайлант хугацаанд үйлдвэрийн осол бүртгэгдээгүй.

Тусгагдсан зорилт: 3.2.7. Ажилчдыг шаардлагатай нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.7.1. Техник технологийн хэлтсийн засвар үйлчилгээний станцын засварчдад жилд нэг удаа, автобусны жолоочид жилд нэг удаа хөдөлмөр хамгааллын хувцас хуваарийн дагуу олгож байна.

3.2.7.2. Өвлийн хос хувцас 67 ширхэг, өвлийн куртка 8 ширхэг, жолоочийн хантааз 160 ширхэг, өвлийн ажлын гутал 67 ширхэг, инженер, техникийн 8 ажилчдад 2 жилд нэг удаа ажлын хувцас олгосон. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан.

Тусгагдсан зорилт: 3.2.8. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.8.1.Газрын даргын 2022 оны А/08 дугаар "Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай" тушаалаар шинэчлэн найруулж, нийтэд илэрхий болгон үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

3.8.2.2.Хөдөлмөрийн гэрээг 400 гаруй ажилчин, албан хаагчидтай байгуулж гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан.

Тусгагдсан зорилт:3.2.9.Ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрын хүрээнд:

3.2.9.1.Үйлдвэрийн газрын 10 үндсэн ажилтанг "Гэрлэх ёслолын ордон"-д хуримлуулах ажлыг зохион байгуулж 5 ажилтанг хамруулсан.

3.2.9.2.Ажилчдыг дотоод сүлжээнд холбох, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.

3.2.9.3.Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ ажилтнуудаас хүчирхийлэл, заналхийлэлд өртөх асуудал гараагүй.

3.2.9.4.Хэлтэс, нэгжийн дарга нар шаардлагатай үед хэсэгчилсэн болон ганцаарчилсан уулзалтыг зохион байгуулж, зан харилцаа, ажлын байран дахь сэтгэл ханамжийн аятай нөхцлийг бүрдүүлсэн.

3.2.9.5.Хоёр ажилтанд мэргэшсэн инженерийн зэргийн нэмэгдэл олгосон.

3.2.9.6.Хамтын гэрээний заалт, цалин хөлсний журмын дагуу ажилчдад сар бүр, хоол, унааны хөнгөлөлт олгосон.

3.2.9.7.Ажилчдын дэлгэрэнгүй судалгаа гаргаж, баяжуулалт хийсэн.

3.2.9.8.Цагаан сар болон ахмадын баярын өдрийг тохиолдуулан 302 ахмад ажилчдад хүндэтгэл үзүүлсэн.

3.2.9.9.Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан 30 алба хаагч нарын 0-16 насын хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл өгсөн.

3.2.9.10.Эрүүл мэндийн хугацаат үзлэгт 216 алба хаагч хамрагдсан.

3.2.9.11.Байгууллага, салбарын болон төрийн шагналд 56 ажилчдыг шагнасан.

3.2.9.12.Мөн олон нийтийн ажил болон байгууллага болон нийслэлээс зохион байгуулж буй ажилд ажилчдад цалинтай чөлөө олгож оролцоог хангаж ажилласан.Хэрэгжилт 100%

Хүрсэн-үр дүн:Ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг тодорхой хэмжээнд хангагдсан.

Тусгагдсан зорилт:3.2.10.Байгууллагын 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу ажилчдад зориулсан сургалтыг зохион байгуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:2022 оны сургалтын төлөвлөгөөгөөр 35 сургалт төлөвлөгдсөнөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 22 сургалт цуцлагдаж, нэн шаардлагатай 13 сургалтад хамруулсан.

3.2.10.1.Архивч, хүний нөөцийн ажилтанг Архивийн ерөнхий газраас зохион байгуулсан Архив, албан хэрэг хөтлөлийн сургалтад хамруулж мэргэжлийн үнэмлэх авсан.

3.2.10.2.Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн дарга мэргэшсэн инженер бэлтгэх сургалтад хамрагдаж Автотээврийн удирдлага зохион байгуулалтын "Мэргэшсэн инженер" -ийн зэрэг,

3.2.10.3.Хэсгийн дарга, тээвэр хөдөлгөөн зохицуулагч нар Монголын автотээврийн холбооны, "Тээвэр хөдөлгөөн зохицуулагч"-ын сертификат

3.2.10.4.Санхүү, бүртгэлийн хэлтсийн Нягтлан бодогч нар "Нягтлан бодох бүртгэлийн мэргэшүүлэх сургалт"-д хамрагдсан.

3.2.10.5.Төрийн худалдан авах ажиллагааны газраас “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан.

3.2.10.6.Сэлбэгийн няравыг Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны харьяа сургалтын төвд “Нярав”-ын сертификаттай сургалтад тус тус хамрагдаж амжилттай төгссөн.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Ажилчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлсэн.

Тусгагдсан зорилт:3.2.11.Орон гэргүй, түрээсийн орон сууцад амьдарч байгаа ажилтнуудын асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 2022 онд ажилчдын амьжиргааны түвшингийн талаарх судалгааг гаргаж (124 ажилтан) судалгаанд тулгуурлан удаан жил тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажилласан 1 гэрийн 2 ажилтанд иж бүрэн монгол гэр, 1 ажилтанд байрны урьдчилгаа, 1 ажилтанд сургалтын төлбөр олгосон. Түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах тухай хүсэлтийн Нийслэлийн засаг даргын Тамгын газар, Нийслэлийн орон сууцны корпорацид уламжилсан.Хэрэгжилт 100%

Тусгагдсан зорилт:3.2.12.Байгууллагын ажилчдын цэцэрлэгийн насны хүүхдүүдийг 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгт хамруулж, урлаг спортын авъяастай хүүхдүүдэд урамшуулал олгох ажлыг зохион байгуулах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Боловсролын сайдын тушаалаар харьяаллын дагуу бүх хүүхдийг цэцэрлэгийн асуудлыг 100 хувь шийдвэрлэх зорилт тавьсаны хүрээнд нийт хүүхдүүд цэцэрлэгт хамрагдсан.

Тусгагдсан зорилт:3.2.13.Байгууллагын захиргаа болон ҮЭ-ийн хороо хоорондын “Хамтын гэрээ”-ний дагуу ажилчдын нийгмийн асуудлыг шийдэж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Хамтын гэрээний хүрээнд өндөр насны тэтгэвэрт гарсан 9 ажилтан 69,282,340 бусад 35 ажилтаны тэтгэмж 41,145,257 нийт 110,427,597 төгрөгийг тэтгэмжид олгосон.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Ажилчдад хамтын гэрээний дагуу тэтгэмж олгосон.

Тусгагдсан зорилт:3.2.14.Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг стандартын дагуу явуулж, тайлан гаргаж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.14.1.2022 оны байгууллагын архивын төлөвлөгөө боловсруулж захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн даргаар батлуулан хагас жилийн тайлан гаргаж удирдлагад танилцуулсан.

3.2.14.2.Байгууллагын дэргэдэх баримт нягтлан шалгах комисс хуралдаж 2021 оны хөтлөгдөж дууссан баримтын бүртгэлийг хянан хэлэлцэж 2022 онд хөтлөгдөх ХХНЖ-ыг хянан газрын даргаар батлуулсан.

3.2.14.3.Баримт нягтлан шалгах комиссын тушаал болон байгууллагын архивын журмыг шинэчлэн гаргасан.

3.2.14.4.Байгууллагын архивын баримтад нэгдсэн тооллого явуулан, тооллогоор илэрсэн зөрчлийг арилгах, хадгалах хугацаа дууссан баримтын жагсаалт үйлдэн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Ажлын явц 70%-тай.

3.2.14.5.ERP системээр 491 албан бичиг хүлээн авч, холбогдох ажилтанд удирдлагын зааврын дагуу хугацаанд нь шилжүүлсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг стандартын дагуу Нийслэлийн архивын газарт явуулж, тайлан тоо мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

Тусгагдсан зорилт: 3.2.15. Байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийг хийж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Байгууллагын архивт 2021 оны хөтлөгдөж дууссан баримтыг хэлтэс нэгж бүрээр хуваарь гарган хуваарийн дагуу 300 баримт хүлээн авч эмхлэн цэгцэлж, данс, бүртгэл үйлдэж, даргын Б тушаал-500, А тушаал-65-ыг байгууллагын archives Edoc системд шивж оруулсан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Нийслэлийн архивын газарт DVD дээр хуулбарлан хүлээлгэн өгч нөхөн бүрдүүлэлт хийж ажилласан

Тусгагдсан зорилт: 3.2.16. Хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллаж, тайлан гаргах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тайлант хугацаанд нийт 303 албан бичиг ирснээс хариутай 96, хариугүй 207 байна. Үүнээс Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэст-54, Санхүү, бүртгэлийн хэлтэст-22, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст-8, Техник, технологийн хэлтэст-6, Дотоод хяналт, шалгалтын хэлтэст-6 албан бичиг тус тус цохогдсон. Үүнээс хугацаандаа шийдвэрлэсэн 88, судлагдаж буй 3 албан бичиг байна. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Зөрчилгүй ажилласан.

Тусгагдсан зорилт: 3.2.17. Байгууллагын ажилчид болон гадны байгууллага, иргэдээс өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайлан мэдээг НЗДТГ-т хугацаанд нь хүргүүлж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Байгууллагад нийт 427 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн. Шийдвэрлэгдсэн 426, төслөөр хэлэлцэж байгаа өргөдөл 1, шийдвэрлэлтийн хугацаа 4 хоног 23 цаг 56 минут байна. Үүнээс 427 өргөдөл гомдлыг хугацаандаа шийдвэрлэсэн, шийдвэрлэлтийн явц 100%, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол хүсэлт байхгүй. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Зөрчилгүй, хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.

Тусгагдсан зорилт: 3.2.18. Нийт ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх зорилгоор хөгжөөнт болон спортын тэмцээн, уралдаан, наадам, явган аялал, цасны баяр зохион байгуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.18.1. Нийслэлийн Засаг даргын санаачлагаар Марафон-2022 уралдааны хүрээнд байгууллагын 23 ажилтанг хамруулсан.

3.2.18.2. "Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл мэнд" аяны хүрээнд долоо хоног бүрийн 4 дэх өдрийн 15 цагаас 17 цагийн хооронд спорт зааланд гар бөмбөг, сагсан бөмбөгөөр хичээллүүлж байна.

3.2.18.3. Нийтийн тээврийн салбарын аварга шалгаруулах тэмцээнээс 5 хүрэл медаль хүртсэн.

3.2.18.4. Нийслэлийн засаг даргын тушаалаар зохион байгууллагадсан нутгийн захиргаааны байгууллагуудын тэмцээн гэх мэт уралдаанд байгууллага болон байгууллагын дэргэдэх спорт хамтлаг идэвх оролцоо санаачлагатай зохион байгуулж оролцсон. Эрэгтэй гар бөмбөгийн баг мөнгөн медал хүртсэн амжилттай. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Олон нийтийн ажлыг зохион байгуулж, хамт олны идэвхийг сэргээсэн.

Тусгагдсан зорилт:3.2.19.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn, цахим хуудсыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:ERP ulaanbaatar системд 2022 онд байгууллагын бүтэц орон тоог оруулсан. ERP системд 2022 онд 12 ажилтанг шинээр бүртгэж, 3 ажилтанг албан тушаал дэвшүүлж өөрчилж, 13 ажилтанг системээс чөлөөлсөн. 1 удаагийн ERP системийн сургалт орсон. Цаг бүртгэл дээр 35 ажилтныг бүртгэгдэж байна. 2 хэлтсийн даргын тоон гарын үсгийг шинээр захиалж авсан.
Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:ERP UB системийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан.

Тусгагдсан зорилт:3.2.20.Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг хэрэглэж хэвших

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны "Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн IV шат, Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсэг, НЗД-ын 2020 оны А/453 дугаар захирамжаар батлагдсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" зэрэг эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус байгууллага нь 2021 оны 04 сарын 27-ны өдрөөс эхлэн цахим албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг хэрэглэж үйлдвэрийн газрын дарга О.Ганбаатар, ЗУХНХ-ийн дарга П.Алтантөгс нар тоон гарын үсэг хэрэглэж хэвшин нийт 478 албан бичиг тоон гарын үсгээр илгээгдсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Тоон гарын үсэг хэрэглэж хэвшсэн.

Тусгагдсан зорилт:3.2.21.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр шинэчлэх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:"Хөдөлмөрийн дотоод журам" А/08 дугаар тушаалаар, "Ажлын байрны тодорхойлолт"-ыг А/09 дугаар тушаалаар,"Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс байгуулах тухай" А/48 дугаар тушаалаар,"Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм батлах тухай" А/51 дугаар тушаалаар,"Даргын зөвлөл, зөвлөлийн ажиллах журам батлах тухай" А/62 дугаар тушаалаар,"Удирдах ажилтнуудын шуурхай хуралдааны дэг батлах тухай" А/32 дугаар тушаалаар баталсан.
Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан.

Тусгагдсан зорилт:3.2.22.Байгууллагын хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, аливаа эрсдэлээс сэргийлэх, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, ажилчдад хууль эрх зүйн зөвлөгөө өгөх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Тээврийн цагдаагийн албатай хамтран Нийтийн тээврийн автобусны жолооч нарт Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм, болон бусад холбогдох хууль зүйн мэдээллийг урьдчилан сэргийлэх үүднээс мэдээллийг хүргэж нийт 75 жолооч хамрагдсан бөгөөд Зам тээврийн осол зөрчилд холбогдсон 76 нийтийн тээврийн автобусны жолооч нарт хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Ажилчдад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Тусгагдсан зорилт:3.2.23.Эрхлэх асуудлын хүрээнд үүссэн шүүхийн маргааны шийдвэрлэлт, явц, үр дүнгийн талаар дээд шатны байгууллагад тогтоосон хугацаанд тайлагнаж мэдээлэх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн ажиллаж иргэний хэргийн 10, үүнээс 4 иргэний хэргийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр 6 иргэний хэрэг процессийн ажиллагаа явагдаж, эрүүгийн хэргийн 3, үүнээс 3 хэргийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр. Зам, тээврийн осол, зөрчилд холбогдсон 12 зөрчлийн хэрэгт иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчаар томилогдон ажилласан.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Хуулийн этгээдийн эрх ашиг сонирхол хамгаалагдсан.

Тусгагдсан зорилт:3.2.24.Байгууллагын 2022 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг бодит тоо баримт, мэдээлэлд үндэслэн тооцоолох

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:2022 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын төслийг боловсруулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн НӨХГ-ын 2/457 дугаар албан бичгээр 2022 оны нийт орлогыг 17,370,529.7 (арван долоон тэрбум гурван зуун далан сая таван зуун хорин есөн мянга долоон зуу) мянган төгрөг, нийт зардлыг 21,524,112.9 (хорин нэгэн тэрбум таван зуун хорин дөрвөн сая нэг зуун арван хоёр мянга есөн зуу) мянган төгрөг, алдагдлыг 4,153,593.2 (дөрвөн тэрбум нэг зуун тавин гурван сая таван зуун ерэн гурван мянга хоёр зуу) мянган төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал 1.24 төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,055,880.0 (нэг тэрбум тавин таван сая найман зуун наян мянга) мянган төгрөг байхаар тус тус батлуулсан.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилт хэрэгжсэн.

Тусгагдсан зорилт:3.2.25.Байгууллагын он дамжсан өр авлагыг үе шаттайгаар бууруулж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Байгууллагын он дамжсан өр авлагыг үе шаттайгаар бууруулж ажиллаж байгаа бөгөөд 2018 оноос хойш хуримтлагдаад байсан нийгмийн даатгалын шимтгэлийн өр болох 2,5 тэрбум төгрөгийн өрийг 1,7 тэрбум болгон 30%-иар бууруулан ажилласан. 2018 оноос хойш хуримтлагдаад байсан хүн амын орлогын албан татварын 782 сая төгрөгийн өрийг 734 сая төгрөг 6,1 хувиар бууруулсан.Үлдсэн хуримтлагдсан өрийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан төлж дуусгахаар зорилт тавин ажиллаж байна. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Халагдсан ажилчдын авлага-26,4%, сэлбэг-51,8%, шатахуун-60%, ХХОАТ-ын дундын суутгал-71%, НДШ-0,6%, байгууллагад төлөх өглөгийг-68%-аар тус тус бууруулан ажилласан.

Тусгагдсан зорилт:3.2.26.Тогтоосон хууль тогтоомжийн дагуу байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийж, ашиглалтын хугацаа дууссан, үлдэгдэл өртөггүй, шаардлага хангахгүй болсон тавилга эд хогшлыг актлуулах, саналыг НӨАУГ-т хүргүүлэх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Байгууллагын даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/44 дугаар тушаалаар батлагдсан комисс хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь тоолж дуусгасан. Тооллогын явц, үр дүнд нийт 268 ширхэг буюу 5,755,341.35 төгрөгийн хөрөнгө актлуулах саналыг хүргүүлж данс бүртгэлээс хассан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Дутагдсан хөрөнгө байхгүй

Тусгагдсан зорилт:3.2.27.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу явуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 29 ажил тусгагдсанаас 2 худалдан авалт шууд хийгдэж, 27 худалдан авах ажиллагаа зохион

байгуулах байснаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 12 ажил цуцлагдаж, 16 ажил цахимаар зарлагдаж үр дүн гарч 13 гэрээ байгуулагдаж, 2 ажил нээгдсэн мөн Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотой тэвчиж болох бусад зардлыг танан 1,195,500.0 мянган төгрөгийн төсөвтэй долоон төндөрийг цуцалсан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Зөрчилгүй ажилласан.

Тусгагдсан зорилт:3.2.28.Төндөрийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд худалдан авах ажиллагааг 100% цахим хэлбэрээр явуулж, иргэд, олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 20 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр 100 хувь явуулсан. 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 29 ажил тусгагдсанаас 2 худалдан авалт шууд хийгдэж, 27 худалдан авах ажиллагаа зохион байгуулах байснаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 12 ажил цуцлагдаж, 16 ажил цахимаар зарлагдаж үр дүн гарч 13 гэрээ байгуулагдаж, 2 ажил нээгдсэн байна. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Төндөрүүд нь холбогдох хуулийн дагуу цахим хэлбэрээр явагдсан.

Тусгагдсан зорилт:3.2.29.Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Тайлант онд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг Даргын захирамж, НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавраас өгсөн нийт 36 шийдвэрийн 44 заалт тус үйлдвэрийн газарт “Бүрэн хэрэгжив” гэж дүгнэв. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгч ажилласан.

Тусгагдсан зорилт:3.2.30.Байгууллагын эхний хагас жилийн тайланд явцын үнэлгээ, жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэх:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Байгууллагын 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоол Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн нийт 14 чиглэлийн хүрээнд 82 ажлыг төлөвлөг ажилласан. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6.2 дахь хэсэгт заасан аргачлалаар хяналт, шинжилгээ үнэлгээ хийж 92,9 %- тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Хэлтсүүдийн төлөвлөгөө, тайланд хяналт, шалгалт хийж, зөвлөгөө өгсөн.

Тусгагдсан зорилт:3.2.31.Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.31.1.Газрын даргын баталсан 02 дугаар удирдамжийн дагуу Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, шалгалтаар 23 зөрчил илэрсэн. Хийсэн ажлын тайланг газрын даргад танилцуулж, СБХ-т зөвлөмж,

зөрчлийн хуудасны хамт хүргүүлсэн. СБХ-ээс зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан ирүүлсэн.

3.2.31.2.Газрын даргын баталсан 04 дүгээр удирдамжийн дагуу Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, шалгалтаар 14 төрлийн зөрчил илэрсэн, хэлтсийн үйл ажиллагааг 59,9%-тай дүгнэсэн. Ажлын үр дүнгийн талаар газрын даргад танилцуулж, хэлтэст зөвлөмж хүргүүлсэн, зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан ирүүлсэн. Газрын даргын баталсан 05 дугаар удирдамжийн дагуу Санхүү, бүртгэлийн хэлтсийн сэлбэгийн нярвын хариуцаж буй сэлбэгт хэсэгчлэн тооллого явуулсан. Тооллогоор 3 төрлийн зөрчил илэрсэн.СБХ-т зөвлөмж, зөрчлийн хуудасны хамт хүргүүлсэн.

3.2.31.3.Техникийн бүрэн бүтэн байдлыг 16 үзүүлэлтээр шалгахад 40 автобус буюу 72,7% нь зөрчилтэй, техникийн бүрэн бүтэн байдал хангалтгүй гэж дүгнэн дүгнэлтийг Техник, технологийн хэлтсийн даргад танилцуулж зөрчлийг арилгах арга хэмжээ зохион байгуулж, 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэх мэдэгдэл өгсөн.

3.2.31.4.Нийслэлийн нийтийн тээвэртэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан. 2022 оны 1 дүгээр улиралд 78204:52:00 даалгаварт цаг гүйцэтгэхээс 68663:20:30 цаг гүйцэтгэж, нийт 9541:32:30 цагийг алдагдалтай үүнээс ашиглалт, техникийн сааталтай цаг, жолоочоос хасах цаг нийт 5657:48:30 цаг, смартаас авах 2394:21:30 цагийг аваагүй тухай бүрт алдагдсан цагийг авсан талаар ээлжийн инженерүүдтэй тулгалт хийж тооцдоггүйгээс даалгаварт цагийн гүйцэтгэлийн хувь 90%-д хүрээгүй. Өмнөх оны мөн 1 дүгээр улиралтай харьцуулахад ашиглалтын саатал 1007:20:30 цагаар өссөн, жолоочоос хасах цаг 51:27:30 цагаар өссөн, смартаас авах зөрүү цаг 2414:33:00 цагаар өссөн. Цагийн гүйцэтгэлийн хувь 2021оны 1 дүгээр улиралд 97,4 % байсан бол 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 87,7% гүйцэтгэж 9,7%-иар буурсан. Зөрчлийг газрын даргад болон ТҮХ-ийн дарга М.Сонинбаатар нарт танилцуулж, илэрсэн зөрчлүүдийг арилгах, зөвлөмж хүргүүлсэн. Зөрчилтэй цаг 05%-иар буурч, цагийн түвшин 2,5%-иар өссөн.

3.2.31.5.Зам тээврийн осол, зөрчил гаргасан ТҮХ-ийн автобусны жолооч нарын зөрчлийн мэдээг гаргаж хэлтсийн дарга М.Сонинбаатарт танилцуулан, зөрчил гаргасан жолооч нарт сургалт зохион байгуулж, аюулгүй ажиллагааны давтан зааварчилга өгөх талаар зөвлөмж хүргүүлж, хяналт, шалгалтыг хийхэд 6 жолоочид аюулгүй ажиллагааны зааварчилга өгөөгүй байсныг нөхөж өгүүлсэн.

3.2.31.6.Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй автобусны жолооч нарын стандарт мөрдөлтийг онлайн камерын тусламжтайгаар илрүүлж, тухай Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст зөвлөмж хүргүүлж ажилласан. Жолооч нар 2020 онд 5 төрлийн 206 зөрчил, 2021 онд 5 төрлийн 125 зөрчил 2022 онд 5 төрлийн 518 зөрчил гаргаж зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 393 зөрчлөөр нэмэгдсэн нь 170 жолоочийн 105 жолооч буюу 61,7% нь шинээр ажилд орсон жолооч байсантай холбоотой. Зөрчил дутагдлыг арилгуулах талаар Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст 7 удаагийн зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн авсан арга хэмжээг илтгэх хуудсаар ирүүлсэн. Зөрчил гаргасан жолооч нарт Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсээс урамшуулалт цалинг 5-10%-иар хасч тооцсон.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдсан.

Тусгагдсан зорилт:3.2.32.Тээврийн хэрэгслийн GPS-ийн хяналтын системийг хэрэгжүүлэх, тээврийн хэрэгслийн смартын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.32.1. Тайлант хугацаанд 11 удаа давхардсан тоогоор 251 автобусанд засвар үйлчилгээний ажлыг "Улаанбаатар Смарт Карт" ХХК-ны засварын инженерүүдтэй хамтран хийж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.

3.2.32.2. Парк шинэчлэлтийн хүрээнд орж ирсэн 11 автобуснаас 11 автобусанд смарт тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг хийж шугамын үйлчилгээнд гаргасан.

Хэрэгжилт 100%

Хэсгийн дундаж үнэлгээ: 95,7%

Гуравдугаар бүлгийн хэрэгжилтийн дундаж хувь: 91

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОДБАЙДАЛ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
4.1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.			
4.1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн.	Байгууллагын эрхэм зорилго үйл ажиллагааны зорилтыг нийтэд таниулах зорилгоор сайт болон пэйж хуудасны мэдээллийг шинэчлэн байршуулж ажилласан.	100%
4.1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг.	https://bus3.ub.gov.mn/ https://www.facebook.com/Bus3.ub	100%
4.1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийг байгууллагын цахим хуудас болон холбогдох дээд байгууллагын цахимд байршуулж олон нийтэд таниулж ил тод байдлыг хангаж ажилласан.	100%
4.1.3	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан.	https://www.facebook.com/Bus3.ub https://bus3.ub.gov.mn/тус тус цахим хуудсанд 3-н мэдээллийг мэдээлж ажилласан.	100%
4.1.4	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан.	Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн дагуу хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгийг цахим хуудсанд 8 бичиг баримтыг нийтэлж нийтэд мэдээлж ажилласан.	100%
4.1.5	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт.	https://bus3.ub.gov.mn/ хуудсанд байршуулж нийтэд мэдээллэж ил тод байдлыг хангаж ажилласан.	100%
4.1.6	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг.	Байгууллагын хэлтсүүдийн мэдээлэл болон удирдах албан тушаалтны овог нэр, цахим хаяг утасны дугаарыг https://bus3.ub.gov.mn/ хуудсанд байршуулж нийтийн ил тод байдлыг хангаж ажилласан.	100%
4.1.7	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ.	Байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг нийслэлийн цахим систем egr.ulaanbaatar.mn -д байршуулж мэдээ тайланг сар бүр нийслэлийн тамгын газарт хүргүүлж ажилласан.	100%
4.1.8	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл.	Байгууллагын талаар болон салбарын талаарх статистик мэдээллийг нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлж https://bus3.ub.gov.mn/ цахим хуудсанд байршуулж ажилласан.	87%

**"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

4.1.9	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Нийслэлийн Засаг даргын болон байгууллагын санаачилгаар зохион байгуулагдаж буй аян, уриалга, арга хэмжээнд албан хаагчид болон олон нийтийг уриалсан постер, чөллөнжийг 4-н удаа зохион байгуулж ажилласан.	100%
Хэсгийн дундаж 96%			
4.2. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал.			
4.2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл.	Ажлын байрны дутагдалтай орон тоог бүрдүүлэх зорилгоор байгууллагын сайт болон пэйж, гэрээт байгууллагаар дамжуулан зар мэдээг байршуулж ил тод нээлттэй зарлаж ажилласан.	100%
4.2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам.	Ажилд орох хүсэлттэй иргэдэд нээлттэй байлгах зорилгоор байгууллагын сайтад ажилд орох анкет болон өргөдлийн маягтыг байршуулж ажилласан.	100%
4.2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм.	https://bus3.ub.gov.mn/ хуудсанд байршуулсан.	100%
4.2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам.	https://bus3.ub.gov.mn/ хуудсанд байршуулсан.	100%
4.2.5.	Хүний нөөцийн удирдлага ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.	https://www.facebook.com/Bus3.ub https://bus3.ub.gov.mn/ тус тус цахим хуудас болон нийслэлийн болон нийтийн тээврийн пэйж хуудсанд шэйр хийж мэдээллийг олон нийтэд мэдээлсэн.	100%
4.2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Байгууллагын хэмжээнд бодлогын түвшинд хэрэгжүүлж буй шийдвэрийг дараах хуудсанд байршуулсан.	80%
Хэсгийн дундаж 98.3 хувь			
4.3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.			
4.3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл.	Сар бүр холбогдох мэдээ тайланг https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ хуудсанд мэдээлсэн.	100%
4.3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан.	Сар бүр холбогдох мэдээ тайланг https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ хуудсанд мэдээлсэн.	100%
4.3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.	Сар бүр холбогдох мэдээ тайланг https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ хуудсанд мэдээлсэн.	100%
4.3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ.	Сар бүр холбогдох мэдээ тайланг https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ хуудсанд мэдээлсэн.	100%
4.3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар.	Сар бүр холбогдох мэдээ тайланг https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ хуудсанд мэдээлсэн.	100%
4.3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр,	Сар бүр холбогдох мэдээ тайланг https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ хуудсанд мэдээлсэн.	100%

**"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2022 оны
үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**

	санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг.		
4.3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт.	Cap бүр холбогдох мэдээ тайланг https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ хуудсанд мэдээлсэн.	100%
4.3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ https://tender.gov.mn/	100%
4.3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/	100%
4.3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт, шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан.	Тухай бүр байгууллагын худалдан авах төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ https://tender.gov.mn/	100%
4.3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ https://tender.gov.mn/	100%
4.3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/ https://tender.gov.mn/	100%
4.3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://shilendans.gov.mn/ https://bus3.ub.gov.mn/	100%
Хэсгийн дундаж 97.6%			
4.4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.			
4.4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://bus3.ub.gov.mn/ https://www.facebook.com/Bus3.ub	100%

4.4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://bus3.ub.gov.mn/ https://www.facebook.com/Bus3.ub	100%
Хэсгийн дундаж 100%			
4.5. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал.			
4.5.1.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://bus3.ub.gov.mn/ https://www.facebook.com/Bus3.ub	100%
4.5.2.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://bus3.ub.gov.mn/ https://www.facebook.com/Bus3.ub	100%
4.5.3.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://bus3.ub.gov.mn/ https://www.facebook.com/Bus3.ub	100%
4.5.4.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://bus3.ub.gov.mn/ https://www.facebook.com/Bus3.ub	100%
4.5.5.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт.	Тухай бүр мэдээллийг дараах хуудсанд мэдээлж ажилласан. https://bus3.ub.gov.mn/ https://www.facebook.com/Bus3.ub	100%
Хэсгийн дундаж 86%			
Нийт дундаж 95.8%			

ТАВДУГААР БҮЛЭГ:БУСАД МЭДЭЭЛЭЛ

**ХОЛБОГДОХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БУСАД
БАЙГУУЛЛАГАТАЙ АЖЛЫН УЯЛДАА ХОЛБООГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН
АЖИЛЛАСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ:**

**Тусгагдсан зорилт:5.1.Зөвлөмж, хүсэлт, албан даалгавар, албан шаардлагын дагуу
ажил зохион байгуулах, хамтарч ажиллах**

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Холбогдох чиг үүргийн хүрээнд манай байгууллага Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Өмчийн ашиглалт, удирдлагын газар, Нийтийн тээврийн Үйлчилгээний газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Тээврийн цагдаагийн алба байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаж, албан даалгавар, албан шаардлагыг цаг тухай бүрд биелүүлж ажилласан. Хэрэгжилт 100%

**Тусгагдсан зорилт:5.1.1.Нийслэлийн нийтийн тээврийн газартай ажил үүргийн хувьд
хамтарч ажиллах**

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Тайлант хугацаанд Нийслэлийн нийтийн тээврийн газартай байгууллагын тээвэрлэлтийн мэдээ тайланг ННТГ-т сар бүр хүргүүлэн ажилласан. “Ажил үйлчилгээ эрхлэн явуулах тухай” гэрээг сар бүр дүгнүүлж ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Зөрчлийн мэдээг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Тусгагдсан зорилт:5.1.2.Нийслэлийн Цагдаагийн газартай хамтарч ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Хяналтын оператор Д.Баянмөнх Нийслэлийн тээврийн цагдаагийн газар-5, Гадны иргэнээс-5, Дотоод ажилтнаас-11 гаргасан хүсэлтийг байгууллагын даргад уламжлан, удирдлагын зөвшөөрлөөр хяналтын камерын бичлэг шүүж өгсөн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Хүсэлтийг хугацаанд барагдуулсан.

Тусгагдсан зорилт:5.1.3.Нийслэлийн Удирдлагын төвтэй хамтран ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Тайлант хугацаанд Нийслэлийн тээврийн цагдаагийн газар -5, хувь иргэн-5, 11 ажилтан нийт 21 удаа камерын бичлэгийг шүүж холбогдох материалыг гаргаж өгч өргөдөл хүсэлтийг хугацаанд нь барагдуулж ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажилласан

Тусгагдсан зорилт:5.1.4 “Улаанбаатар Смарт Карт” ХХК-тай хамтран ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Тайлант хугацаанд 11 удаа давхардсан тоогоор 71 автобусанд засвар үйлчилгээний ажлыг “Улаанбаатар Смарт Карт” ХХК-ны засварын инженерүүдтэй хамтран гүйцэтгэж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.

-Парк шинэчлэлтийн хүрээнд орж ирсэн 11 автобусаас 11 автобусанд смарт тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг хийж, шугамын үйлчилгээнд гаргасан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Засвар үйлчилгээний ажлыг цаг хугацаанд нь хийж автобуснуудыг шугамын үйл ажиллагаанд гаргасан.

Тусгагдсан зорилт:5.1.5.СХД-ийн 41 дүгээр хороотой хамтран ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Ерөнхий механикийн хэсэг СХД-ийн 41 дүгээр хороотой хамтран ажиллаж, 2022.01.01–2022.06.15-ны хооронд СХД-ийн Засаг даргын

албан даалгаврын дагуу сард 2 удаа цэвэрлэгээ хийж тайланг холбогдох хугацаанд
явуулсан. Хэрэгжилт 100%

Зураг 5. Бүх нийтийн цэвэрлэгээ



Хүрсэн үр дүн: Байгууллагын орчин тойрны цэвэрлэгээ сайжирсан. Хэрэгжилт-100%

Нийслэлийн тээврийн үйлчилгээний газрын иргэдэд хандсан нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт мэдээллийг авах дугаар бүхий зурагт хуудас жижиг, том хэмжээтэй стандартын дагуу хэвлүүлж, нийт 80 автобусны зааланд тогтоон байрлуулсан.

Нийслэлийн тээврийн газрын 70044040, 326352 дугааруудыг тогтмол ажиллуулж, санал гомдлыг хүлээн авч байгууллагуудад мэдээлж шуурхай барагдуулж, гомдол гаргагчид хариу мэдэгдэж ажилласан. Зорчигчдоос ирж буй гомдол саналын дийлэнх хувь нь шугамын үйлчилгээ, зан харьцаатай холбоотой гомдол эзэлж байсан тул тээвэр ашиглалтын улсын байцаагч нартай харилцан ажлын уялдаатай ажиллаж, захиргааны арга хэмжээ тооцуулан нийт 6 санал гомдлыг шуурхай барагдуулж, гомдол гаргагчид хариу мэдэгдэж ажилласан.

Тайлант хугацаанд НТҮГ-ын үүрэг даалгаврын дагуу давхардсан тоогоор 38 шалгагчийг шугамын үйлчилгээний автобусанд зорчигч нарт зөвлөгөө өгөх, хөлс төлөлтөд хяналт тавьж ажиллуулсан.

Хүрсэн үр дүн: Нутгийн захиргааны бусад байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаж, албан даалгавар, албан шаардлагыг цаг тухай бүрд нь биелүүлсэн.

5.2. БАЙГУУЛЛАГЫН ХАРЪЯА НЭГЖҮҮДИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Тусгагдсан зорилт: 5.2. Үндсэн чиглэлийн хүрээнд хийсэн ажлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэст хийсэн хяналт, шинжилгээ

Тусгагдсан зорилт: 5.2.1. Парк шинэчлэлт хийх ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан хөдөлгүүртэй их багтаамжийн 2 давхар 10 автобусаар парк шинэчлэлт хийж шугамын үйлчилгээнд ажиллуулж байна. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: 2 давхар шинэ автобусаар парк шинэчлэлт хийж, шугамын үйлчилгээнд ажиллуулсан.

Тусгагдсан зорилт: 5.2.2. "Нийтийн тээврийн автобус бааз барих" төслийн ажлын гүйцэтгэл:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: "Нийтийн тээврийн автобус парк" барихаар 4,3 га газарт нийт 11 ажлын зураг, төсвийг 2018 онд Нийслэлийн зураг төслийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн.

2018-2022 онд ажлын зураг, төсвийн дагуу нийт 12 компани, ахуйн нэгж байгууллага паркийн барилгын ажлыг гүйцэтгэж байна.

Хүрсэн үр дүн: Тайлант онд: "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын -автобус паркийн

- Ногоон байгууламж, зам талбайн ажил хийгдээгүй-0%

- Автобус паркийн харуулын байр барих ажил хийгдэж байна-85%

- ШТС, уурын зуух, худаг барих ерөнхий ажлууд хийгдэж байгаа-85%

- Дэд бүтэц хийгдэж байгаа-45%

- Хашааны суурь бүрэн цутгагдсан-45%

- Цахилгаан хангамжийн ажлууд хийгдэж байна-10%-гэсэн гүйцэтгэлийн үнэлгээтэй явагдаж байна.

Тусгагдсан зорилт: 5.2.3 Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Байгууллагын гүйцэтгэлийн тайлан гараагүй байсан.

Тусгагдсан зорилт: 5.2.4. Төрийн албан хэрэг хөтлөлт, стандартын дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн тайлан, мэдээнд хяналт, шалгалт хийх:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Бичиг хэргийн ажилтан С.Адъяасүрэн тайлант хугацаанд албан хэрэг хөтлөлтийн тайлан мэдээг хугацаанд шивж зөрчилгүй ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Зөрчилгүй байсан.

Тусгагдсан зорилт 5.2.5. Хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайлан мэдээг удирлагад танилцуулсан эсэхэд хяналт шалгалтыг зохион байгуулах:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Бичиг хэргийн ажилтан С.Адъяасүрэн тайлант хугацаанд 51 хариутай бичиг ирснийг удирдлагад танилцуулж хугацаанд нь шийдвэрлүүлж, тайланг хугацаанд нь гаргаж, зөрчилгүй. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Зөрчилгүй ажилласан.

Тусгагдсан зорилт 5.2.6.Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн эсэх, тоон тайлан мэдээнд хяналт, шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт шалгалт хийхэд тайлант хугацаанд 214 хүсэлт хүлээн авснаас хугацаандаа шийдвэрлэсэн 214, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй байна. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Зөрчил гаргахгүй ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөсөн.

Тусгагдсан зорилт 5.2.7.Даргын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл, хөтлөлт, шийдвэрлэлтэд хяналт шалгалт хийх: Хугацаа болоогүй.

Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт

Тусгагдсан зорилт 5.2.8.Нийтийн тээврийн үйлчилгээний газартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт үнэлгээ-шинжилгээ хийх:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Нийслэлийн нийтийн тээврийн газартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 91,1%-аар биелсэн. 2022 оны эхний хагас жилд 78204:52:00 даалгаварт цаг гүйцэтгэхээс 68663:20:30 цаг гүйцэтгэж, нийт 9541:32:30 цагийн алдагдалтай, үүнээс ашиглалт, техникийн сааталтай цаг, жолоочоос хасах цаг нийт 5657:48:30 цаг, смартаас авах 2394:21:30 цагийг аваагүй тухай бүрт алдагдсан цагийг авсан талаар тээвэр, хөдөлгөөн зохицуулагчтай тулгалт хийж тооцдоггүйгээс даалгаварт цагийн гүйцэтгэл 90%-д хүрээгүй.

Хүрсэн үр дүн:Гэрээний үүргийн биелэлтийг улирал тутам хянаж ажилласан.

Тусгагдсан зорилт 5.2.9.Тээвэр, хөдөлгөөн зохицуулагчийн өдөр тутам гаргаж буй хөдөлгөөний мэдээнд хяналт, шалгалтыг зохион байгуулах:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Тайлант хугацаанд шугамын үйлчилгээнд ажилласан ТВОХ-ын ажлын гүйцэтгэлийн мэдээнээс зогсоолд зогсоогүй 103 зөрчлийг илрүүлж, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст зөвлөмж хүргүүлж ажилласан.

Хүрсэн үр дүн:ТВОХ-ын жолооч нарын зогсоолд зогсоогүй зөрчил өмнөх оны эхний хагас жилд 159 зөрчил гарч байсан хяналт шалгалтын үр дүнд 56 зөрчлөөр буурсан үзүүлэлттэй.

Тусгагдсан зорилт 5.2.10 “Улаанбаатар Смарт Карт” ХХК-ийн гаргаж байгаа ажлын гүйцэтгэлд хяналт, шалгалт хийх:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Тайлант хугацаанд “Улаанбаатар Смарт Карт” ХХК-аас 2394:21:30 цагийг аваагүй байсан.Тооцолсон цагийг дутуу авснаар байгууллагад орж ирэх санхүүжилтэд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэж байна.

Хүрсэн үр дүн:Ажлын үр дүнг газрын даргад танилцуулсан.

Тусгагдсан зорилт 5.2.11.Нийтийн тээврийн үйлчилгээний газартай шугамын хяналтын талаар хамтарч ажиллах:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Нийтийн тээврийн үйлчилгээний газрын тээврийн хяналтын хэлтэст сар бүрийн ажлын 5 хоногт шугамын мэдээг хүргүүлж ажилласан. Газрын даргын 01 дүгээр удирдамжийн дагуу үйлдвэрийн газрын үйлчилж буй 13 чиглэлд 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд ажлын зураг авалтыг зохион байгуулж, ажилласан. Шалгалтын хугацаанд орсон орлого (баярлалаа-29654, ахмад-11470, хөнгөлөлттэй зорчигч-10078, оюутан-7989, хүүхэд-9575, дамжин суулт-6891, тусгай карт-1332) Пос машин-1 сард 14911900 төгрөг, 2 сард 12312700

төгрөг, 3 сард-18334800 төгрөг, нийт 45559400 төгрөгийн орлого хийж, нийт орлогын 1%-ийг байгууллагын дансанд оруулсан.

Хүрсэн үр дүн:Шалгалтын талаар хийсэн ажлын мэдээг Нийтийн тээврийн газарт хугацаанд нь хүргүүлж, удирдлагад танилцуулж, холбогдох хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Тусгагдсан зорилт 5.2.12.Үйлчилгээтэй холбоотой иргэд, зорчигчдоос ирсэн гомдол саналын барагдуулалтад хяналт тавих:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:2021 оны эхний хагас жилд 11 санал гомдол ирж, 2022 онд 16 санал гомдол ирсэн үзүүлэлтэй. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Санал гомдлыг 100% барагдуулсан.

Техник, технологийн хэлтсийн дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт:

Тусгагдсан зорилт 5.2.13.Техникийн тоо бүртгэгчийн АБТ-оор гүйцэтгэсэн ажил үүргийн биелэлтэд хяналт шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Техникийн паспорт хөтлөлтийг, сэлбэгийн няравын анхан шатны баримт, хөдөлгөөний мэдээтэй тулгаж шалгасан.Зарлагаар гарсан сэлбэгтэй тулгаж үзэхэд зөрчилгүй, бичилтийг хийсэн байсан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн:Техникийн паспортыг үнэн зөв хөтөлсөн байсан.

Тусгагдсан зорилт 5.2.14.Засварын инженерүүдийн ажил үүргийн гүйцэтгэл, засварын хуваарь, график мөрдөлтөд хяналт, шалгалт хийх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:2022 оны эхний хагас жилийн байдлаар техникийн саатал 6271:43:00 цаг гарсан. Засварын инженерүүдийн ажил үүргийн гүйцэтгэл, засварын хуваарь, график мөрдөлтөд хяналт, шалгалтын ажлыг шалгах ажлын явц 60%-тай. Техникийн саатал өссөн шалтгааныг сэлбэггүй, засварчдын хөдөлмөр зохион байгуулалт, засварын инженерийн удирдах чадвар, засвар үйлчилгээний чанар зэрэгт хяналт, хийхэд хугацаа шаардлагатай тул 2022 оны 08 дугаар сард дуусгаж, Газрын даргад танилцуулах шийдвэрт хүрсэн. Хэрэгжилт 60%

Хүрсэн үр дүн:Хяналт шалгалтын ажлын 60 гаруй хувийг хийж гүйцэтгэсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд хяналт, шалгалт

Тусгагдсан зорилт 5.2.15.Ажлын байрны эрүүл ахуй, эмх цэгцэд хяналт тавьж ажиллах:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Ажлын байрны үзлэг шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийн талаар өглөөний шуурхайд мэдээлж биелэлтэд нь хяналт тавьж ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан ажлын байрны үзлэг шалгалт хийгээгүй байна. Зөрчлийг арилгах талаар ХАБЭААХА-нд заавар зөвлөгөө өгсөн.Цаашид ажлын байрны үзлэг шалгалтыг тогтмолжуулах, чанартай хийж гүйцэтгэх шаардлагатай. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Ажлын үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан.

Тусгагдсан зорилт 5.2.16.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилга, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:Ажлын байрны урьдчилсан зааварчилгаанд давхардсан тоогоор 89 ажилтан, давтан зааварчилгаанд автобусны жолооч-302, шалгагч-189, техник технологийн хэлтсийн засварчид-96, шалгах механик-32, сантехникийн засварчид 18, тоног төхөөрөмжийн засварчин-8, гагнуурчин-8, цахилгаанчин-6, мужаан-5, тэрэг тавигч-16, тэрэг угаагч-19, аж ахуйн автомашины жолооч-11, үйлчлэгч-9, конторын албан хаагч болон инженер техникийн ажилчид-85, сэлбэг аж ахуйн нярав-10 давхардсан

тоогоор нийт 903 ажилтан хамрагдсан. Тайлант хугацаанд хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдлын үзлэг шалгалтыг 3 удаа, ажлын байрны үзлэг шалгалтыг 8 удаа хийж, илэрсэн зөрчлийн талаар өглөөний шуурхайд мэдээлж биелэлтэд хяналт тавьж ажилласан. Үйлдвэрийн осол бүртгэгдээгүй.

Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Ажлын үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан.

Тусгагдсан зорилт 5.2.17. Галын аюулгүй байдлыг хангаж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Галын аюулгүй байдлын үзлэг шалгалтуудыг зохион байгуулсан боловч ямар хугацаанд, хэдэн давтамжтай хийсэн, цаашид анхаарч ажиллах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан тайландаа тусгаж өгөөгүй. Тодорхой бус байсан. Дээрх асуудлын талаар тайланд тусгаж байхыг холбогдох албан тушаалтанд зөвлөсөн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Ажлын үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан

Санхүү бүртгэлийн хэлтсийн дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт

Тусгагдсан зорилт 5.2.18. Түлш, тос, тослох материалын зарцуулалтанд хяналт шалгалт хийх

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Маслын зарцуулалт, түлшинд хяналт тавьж ажилласан. Ажлын үр дүнгийн талаар удирдлагад танилцуулж, Санхүү, бүртгэлийн хэлтэст зөвлөмж хүргүүлсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Ажлын үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан.

Тусгагдсан зорилт 5.2.19. Сэлбэгийн няравын бүртгэл тооцоо, анхан шатны бичиг баримтад шалгалт хийх:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Сэлбэгийн нярвын сэлбэгийн зарцуулалтын тайлан, түүнтэй холбоотой баримт материалд хяналт, шалгалтыг зохион байгуулж ажилласан. Ажлын үр дүнгийн талаар үйлдвэрийн газрын даргад танилцуулж, СБХ-т хүргүүлсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Ажлын үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан.

Тусгагдсан зорилт 5.2.20. Байгууллагын ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 2022 эхний хагас жилд шилэн дансанд нийт 72 мэдээлэл байршуулахаас 67 мэдээллийг хугацаанд нь байршуулсан. 5 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан. Нийт 14 төрлийн 6,853.1 сая төгрөгийн орлого, 8,874.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээ байршуулсан. Хэрэгжилт 93%

Хүрсэн үр дүн: Ажлын үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан.

Тээврийн хэрэгслийн онлайн камерын хяналт шалгалт хийх

Тусгагдсан зорилт 5.2.21. Онлайн камераар хяналт шалгалтыг зохион байгуулах

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй автобусны жолооч нар 5 төрлийн 334 зөрчил гаргасан. Зөрчил дутагдлыг арилгуулах талаар Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст зөвлөмж хүргүүлсэн. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Ажлын үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан.

Тусгагдсан зорилт 5.2.22 Камер шүүлгэх талаар холбогдох байгууллага, иргэнээс ирсэн албан бичиг, өргөдлийг удирдлагын шийдвэрийн дагуу шүүж баталгаажуулан хүргүүлж ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тайлант хугацаанд Нийслэлийн тээврийн цагдаагийн газар 5, хувь иргэн 5,11 ажилтан нийт 21 удаа дагуу камерын бичлэгийг шүүж холбогдох материалыг байгууллага иргэнд өгч, өргөдөл хүсэлтийг хугацаанд нь барагдуулж ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Хуулийн хугацаанд хүсэлтийг барагдуулж ажилласан.

Тусгагдсан зорилт 5.2.23. Камерын системийн доголдол, DVR төхөөрөмжид гэмтэл илэрсэн "Улаанбаатар Смарт Карт" ХХК-д мэдэгдэж засварлуулах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тайлант хугацаанд 6 удаа автобусанд байрших онлайн камерын засвар үйлчилгээний ажлыг "Улаанбаатар Смарт Карт" ХХК-ийн ажилтнуудтай хамтран хийсэн. Парк шинэчлэлтийн хүрээнд орж ирсэн 10 автобусанд смартын тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг хийж шугамын үйлчилгээнд гаргасан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Засвар үйлчилгээний ажлыг цаг хугацаанд нь хийж автобуснуудыг шугамын үйл ажиллагаанд гаргасан.

Хэсгийн дундаж үнэлгээ 100%

5.3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Тусгагдсан зорилт: 5.3.1 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажлын мэдээлэл

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлт мэдээллийг 24 цагаар тус байгууллагын 86032244 утсаар болон цахим хаягаар хүлээн авч байгууллагын пейж хуудас, нийтийн тээвэр-public ib групп үүсгэн холбогдох мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 5 санал, гомдол жолоочийн нэр дээр хүлээн авснаас жолоочийн зан харьцаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зөрчсөн, стандартын шаардлага хангаагүй, үнэ-тарифтай холбоотой зөрчил байсан тул Тээвэрлэлт үйлчилгээний хэлтэст шилжүүлэн иргэдэд хариу мэдэгдсэн. Гомдол ирсэн жолооч нарыг Нийтийн Тээврийн Үйлчилгээний газрын улсын байцаагч торгох, сануулах, жолоочийн шагналт цалингаас суутгах зэрэг арга хэмжээ тооцсон. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн гомдлыг бүрэн барагдуулсан.

Тусгагдсан зорилт: 5.3.2. Камер шүүлгэх талаар холбогдох байгууллага, иргэнээс ирсэн албан бичиг, өргөдлийг удирдлагын шийдвэрийн дагуу шүүж баталгаажуулах ажлыг зохион байгуулах:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Камер шүүлгэх талаар холбогдох байгууллага, иргэнээс ирсэн албан бичиг, өргөдлийг удирдлагын шийдвэрийн дагуу шүүж баталгаажуулах ажлыг зохион байгуулж тайлант хугацаанд Нийслэлийн тээврийн цагдаагийн газар 5, хувь иргэн 5, 11 ажилтан нийт 21 удаа камерын бичлэгийг шүүж өргөдөл хүсэлтийг хугацаанд нь барагдуулж ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Хүсэлтийг хуулийн хугацаанд барагдуулсан. Гэрээний заалтыг биелүүлж ажилласан.

Тавдугаар бүлгийн хэрэгжилтийн дундаж хувь: 100%

ДҮГНЭЛТ:

№	Ололттой тал
1	Автобусны парк шинэчлэлт хийх зорилгоор БНХАУ-ын "NANJING GOLD" компанид үйлдвэрлэсэн их багтаамжийн 2 давхар 10 цахилгаан автобус худалдан авч, 2022.06.03-ны өдрөөс эхлэн шугамын үйлчилгээнд ажиллуулсан.
2	Нийтийн тээврийн үйлчилгээний газартай байгуулсан гэрээг 92% биелүүлж, хангалттай үнэлгээтэй дүгнүүлсэн.
3	Байгаль орчинд ээлтэй цахилгаан хөдөлгүүртэй их багтамжийн автобусаар парк шинэчилснээр шугамын гаралтын тоог нэмэгдүүлсэн.
4	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн, хугацаа хоцорч шийдвэрлэсэн өргөдөл, хүсэлт байхгүй ажиллаласан.
6	Шугамын үйлчилгээнд ажиллаж буй автобуснууд 100% онлайн камерт холбогдож, шугамын үйлчилгээнд ажиллаж буй автобуснуудын хөдөлгөөнийг хянах удирдлагын хяналтын өрөөг бий болгож, шугам замын үйлчилгээнд ажиллаж байгаа автобусны жолооч нар нийтийн тээврийн стандарт хэрхэн мөрдөн ажиллаж байгааг шууд хянах, зөвлөгөө өгөх боломж бүрдсэн.

№	Дутагдалтай тал, гарсан хүндрэлтэй асуудлууд
1	Зориулалтын бус үйлдвэрийн баазад үйл ажиллагаа явуулж байгаа нь ажлын байрны нөхцөл, ая тухтай байдал алдагдаж, засвар үйлчилгээ хийх цөх, автобус парклуулах гарааш, зам талбай аюулгүй ажиллагаа хангагдахгүй нөхцөл байдал үүсэж байна.
2	Техникийн бэлэн байдлын дундаж 82,5%-иас доошгүй байх зорилтод түвшиндээ хүрээгүй 64,5% байгаа дэвү, каунти,эко автобуснуудын ашиглалтын хугацаа дуусч, сэлбэг материалын олдоц тааруу
3	Санхүүжилт дутуу хийгдсэнээс шалтгаалан нийгмийн даатгалын өртэй. НДШ-ийн өрийг төлөөгүйн улмаас ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилтнууд ажилгүйдлийн тэтгэмж авах, эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

Тайлант хугацаанд 5 бүлэгт 64 ажлыг төлөвлөн хийж гүйцэтгэсэн.

- Нэгдүгээр бүлэг: Бодлогын бичиг баримт бичиг, хэрэгжилтийн үр дүн-82,5
- Хоёрдугаар бүлэг:Тогтоол, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилт, үр дүн-99,5%
- Гуравдугаар бүлэг: Байгууллагын үйл ажиллагааны үр дүн 91 %
- Дөрөвдүгээр бүлэг: Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал 95,8%
- Тавдугаар бүлэг: "Бусад ажил" хэрэгжилт 100%

Ерөнхий дундаж үнэлгээ: 94%

ТАНИЛЦСАН
ДАРГА

О.ГАНБААТАР

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН
ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.АЛТАНТӨГС

